



**“СЭТГҮҮЛЧИЙН ЭРХ
ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬ”-ИЙН ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА**



МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улс дахь Конрад-Аденауэр Сангийн суурин төлөөлөгчийн газар нь тус улсад ардчиллыг хөгжүүлэх үйл хэргийг тууштай дэмжин төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ хүрээнд эрх зүйт төр, нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн тухай мэдлэгийг олон нийтэд таниулах ажлыг өргөн хүрээтэй зохиож ирлээ.

Тус сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар нь сүүлийн жилүүдэд Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэх асуудлаар монгол судлаачдын хийж буй судалгааг дэмжиж, тэдгээрт үндэслэсэн зөвлөмжийг боловсруулан төр засгийн байгууллагуудад санал болгох зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагааг явуулж байна. Эдгээр судалгаа, зөвлөмж нь Сангийн үзэл бодол, байр суурь бус монгол судлаачдын өөрсдийн судалгааны үр дүн байдгаараа онцлог юм.

Конрад-Аденауэр-Сан нь Хэвлэлийн хүрээлэнтэй хамтарсан сэтгүүл зүйн тэтгэлэгт хөтөлбөрийн 2018 оны төгсөгчдийн санаачилгаар үүсгэн байгуулагдсан ПИКАС сэтгүүл зүйн медиа багийн сэтгүүлч, хуульчдаас бүрдсэн хамт олны энэхүү шинэ тутам судалгаа нь хэвлэл мэдээллийн эрх зүйн орчны хөгжилд хувь нэмэр болно гэдэгт бид гүнээ итгэж байна.

Сэнгээгийн Ганзаяа

**Монгол Улс дахь Конрад-Аденауэр Сангийн
Хөтөлбөрийн менежер**

ТӨСЛИЙН БАГ

Үйл ажиллагаа	Багийн гишүүд	Албан тушаал
Судалгаа хийх	М.Баттогтох Б.Номин С.Түвшинжаргал Х.Тунгалаг	Мэргэшсэн Сэтгүүл зүйн Төвийн судлаач
Хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулах	М.Баттогтох Б.Ганзориг Ч.Анар	МУИС-ын ХЗС-ийн докторант МУИС-ын магистрант Хуульч, судлаач

АГУУЛГА

1. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг судлах хэрэгцээ, шаардлага	4
2. Судалгааны зорилго	5
3. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин	6
4. Судалгааны ажлын хүлээгдэж буй үр дүн	8
Судалгааны тайлан	9
<u>Нэгдүгээр бүлэг</u>	
1.1 Монгол Улс дахь сэтгүүл зүйн өнөөгийн байдал	9
1.2 Сэтгүүл зүйн салбарт тулгамдаж буй асуудал	11
1.3 Сэтгүүл зүйн хараат бус байдлын тухай ойлголт	14
1.4 Сэтгүүлчийн хараат бус байдалд нөлөөлдөг зүйлс	16
1.5 Дэлхий нийтийн хандлага/туршлага/	20
<u>Хоёрдугаар бүлэг</u>	
2.1 Монгол Улс дахь сэтгүүл зүйн эрх зүйн орчин	32
2.2 Монгол Улсын Үндсэн хууль	34
2.3 Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын хүний эрхийн тухай хууль тогтоомж ба сэтгүүл зүйн орчин	39
<u>Гуравдугаар бүлэг</u>	
3.1 Монгол Улсын Үндсэн хууль	43
3.2 Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль	44
3.3 Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай хууль	45
3.4 Олон нийтийн радио, телевизийн тухай хууль	46
3.5 Эрүүгийн хууль	49
3.6 Зөрчлийн тухай хууль	50
3.7 Харилцаа холбооны тухай хууль	54
3.8 Радио долгионы тухай хууль	55
3.9 Шуудангийн тухай хууль	55
3.10 Бусад холбогдох хууль (18)	56
<u>Дөрөвдүгээр бүлэг</u>	
4.1 Судалгааны үр дүн	77
4.2 Хуулийн төсөл	81
4.3 Хуулийн төслийн үзэл баримтлал	88
7. Хуулийн төслийн орчуулга	92
7.1 Needs for studying the legal environment for media	
7.3 Law of Mongolia on protection of professional activities of journalists	
8. Ашигласан эх сурвалж	105

1. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг судлах хэрэгцээ, шаардлага

Хэвлэл мэдээллийн байгууллагууд хийгээд сэтгүүлчдийн хараат бус байдлыг хангах чиглэлээр тусгайлсан хууль байхгүйгээс тэдний эрх ашиг зөрчигдөх явдал түгээмэл байна. Үүний гол шалтгаан нь эрх зүйн таатай орчин бүрдээгүйтэй холбоотой юм. Тухайлбал, хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, ивээн тэтгэгчид болон харилцагч байгууллагуудын зүгээс редакцад нөлөөлөх, цаашлаад нийтлэл, нэвтрүүлгийн агуулгыг өөрчлөх, сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулах нь хэвийн үзэгдэл мэт болжээ. Редакцын хараат бус байдлыг Олон нийтийн радио телевизийн тухай хуулиар баталгаажуулсан ч уг зохицуулалт нь зөвхөн Монголын Үндэсний Олон нийтийн радио телевизэд ажиллагсад л хамааралтай байхаар зохицуулсан.

Гэвч Олон нийтийн радио телевизийн Удирдах дээд байгууллагын гишүүдийг УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газрын саналд үндэслэн УИХ-аас томилдог бөгөөд энэхүү томилгоо нь улс төрийн шинжтэйгээс гадна Үндэсний зөвлөлөөс (улс төрчдөөс) Олон нийтийн радио телевизийн редакцын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг олгож байгаа юм. Цаашлаад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд ялсан эрх баригч намын хүн МҮОНРТ-ын ерөнхий захирлаар сонгогддог жишиг тогтоод удаж байгаа билээ.

Мөн түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгчийн тэнцвэртэй байдлыг хангах зохицуулалт огт байхгүйтэй холбоотойгоор үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчид, ивээн тэтгэгчид, сэтгүүлчдийн хувь оролцоог журамлаагүй зэргээс Монгол Улсад сэтгүүлчийн хараат бус байдал хангагдаагүй гэж дүгнэх үндэслэлтэй юм.

УИХ-аас 2010 онд баталсан Монгол Улсын аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна”¹ гэж заасан.” Энэхүү үзэл баримтлалын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс хэвлэл мэдээллийн эзэмшил, харьяаллын ил тод байдлын талаарх заалтын хэрэгжилтийг хангах, хянах ямар нэгэн тогтоол, шийдвэр гаргаагүй өнөөдрийг хүрчээ.

Иймд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд тулгарч буй асуудлуудыг иж бүрнээр нь судалж, сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалт хийх, хуульчлан батлах шаардлага тулгарч байна.

2. Судалгааны зорилго

Монгол Улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөө, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх нөхцөлийг тодорхойлж, холбогдох хуулийн төслүүдийг боловсруулахад чиглэгдэнэ. Мөн төрөөс сэтгүүл зүйн салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэхтэй холбоотой зохицуулалтуудыг тусгах зорилгоор энэхүү судалгааг хийнэ.

Хуулийн төслийг боловсруулахдаа олон улсын сайн туршлага хийгээд өөрийн орны онцлогийг харгалзана. Чингэхдээ нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийн хувьд манай улстай ижил, нэг гараанаас эхэлсэн, хөгжиж буй, ардчилсан улс орнуудын туршлагыг харьцуулан авч үзэх болно.

Судалгааны үндсэн дээр сэтгүүлчийн үйл ажиллагааг эрх зүйн хүрээнд тусгайлан журамлах ажлыг гүйцэтгэж, сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр төслийг боловсруулж хэвлэл мэдээллийн салбарын хүрээнд хэлэлцүүлэх, улмаар шийдвэр гаргах түвшинд холбогдох хуулийн төсөл /”Сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах тухай хууль” эсхүл “Сэтгүүлчийн эрх зүйн байдлын тухай хууль”/-үүдийг танилцуулж, хууль санаачлагчдад санал болгох ажлыг зохион байгуулахад судалгааны зорилго оршино.

3. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин

Монгол Улсын Үндсэн хуулиар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөөг баталгаажуулж, хэвлэн нийтлэх хүний суурь эрхийг хуульчилсан. Мөн хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар цензур, төрийн эзэмшлийн мэдээллийн хэрэгслийг хориглосон. Үүнтэй холбоотойгоор буюу 2005 онд батлагдсан Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн хүрээнд төрийн мэдэлд байсан үндэсний хэмжээний радио, телевизийг олон нийтийн статустай болгож өөрчилсөн билээ.



2011 онд Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулийг баталснаар төрийн байгууллагаас олон нийтийн ашиг сонирхолд хамаарал бүхий мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулсан юм. Тэгвэл 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, гүтгэх, доромжлох асуудлыг эрүүгийн хуулиар бус, Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээр болсон. Гэвч

мэдээлэл тараах” гэдэг гэмт хэргийг шинээр томьёолж, Зөрчлийн хуулиар зохицуулж байсан “гүтгэх” заалтыг хүчингүйд тооцсон.

Энэ бүхнээс хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад төдийгүй олон нийтийн зүгээс бодит байдал дээр хэвлэлийн эрх чөлөө хязгаарлагдмал, эрх зүйн орчин хангалттай бус гэсэн шүүмжлэл дагуулж байна. Үнэхээр ч сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаа, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах явдал сүүлийн үед нэлээд ажиглагдаж байгаа нь нууц биш юм.

Хэвлэл мэдээллийн салбартай холбогдох нийт 40 орчим хууль байна. Тухайлбал: Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Аж ахуйн, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Монгол Улсын Иргэний хууль, Эрүүгийн хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль гэх мэт.

Гэвч дээрх хуулиудад сэтгүүлчийн хараат бус байдлыг хангахтай холбогдсон зохицуулалт тусгагдаагүй.

4. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин

Энэхүү судалгааны үр дүнд хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй сэтгүүлчдийн хараат бус байдлыг хангах нөхцөл эрх зүйн хүрээнд бүрдэх юм. Түүнчлэн хэвлэлийн эрх чөлөө, үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангахад түлхэц болох учиртай.



Ардчилсан нийгмийн гол шалгуур нь чөлөөтэй, бие даасан, олон ургалч үзэлд тулгуурласан хариуцлагатай сэтгүүл зүй оршин тогтнох, хүчирхэгжүүлэх нөхцөлийг шаардаж байдаг. Хүн төрөлхтний жам ёсны эрх болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүний дотор хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн үндсэн юм. Энэ нь уг хуулийн төслийн үзэл баримтлал гол тулгуур хүчин зүйл болно.

Судалгааны ажлын үр дүнд сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж хэвлэл мэдээллийн салбарын хүрээнд хэлэлцүүлэн улмаар хууль санаачлагчид санал болгож УИХ-аар хэлэлцэн батлуулах ажлын үндсэн нөхцөл бүрдэнэ.

Судалгааны тайлан

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

1.1 Монгол Улсын сэтгүүл зүйн өнөөгийн байдал

1913 онд “Шинэ толь” сонин бичиг анх хэвлэгдсэнээр Монгол улсад сэтгүүл зүйн үндэс тавигдсан гэж үздэг. Харин одоогоос 60 жилийн өмнө буюу 1960 онд МУИС-д Сэтгүүл зүйн тэнхим байгуулагдаж Монгол улс мэргэжлийн сэтгүүлчдийг дотооддоо бэлдэж эхэлжээ.

Социалист нийгмийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь эрх баригч намын үзэл суртлын гол зэвсэг болж байв.



Харин 1990 онд ардчилсан хувьсгал ялсны дараа сэтгүүл зүйн салбарт шинэ хувьсал өрнөж, чөлөөт сэтгүүл зүйн үндэс тавигдсан юм. 1998 онд Улсын Их Хурлаас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай дөрвөн зүйл бүхий хуулийг баталсан. Уг хуулиар хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлдээ хариуцлага хүлээх бөгөөд төрөөс олон нийтийн агуулгад цензур тогтоохгүй гэж заасан байдаг. Тухайн үед хувийн сонин, сэтгүүл, телевиз, радио олноор бий болж, хөгжиж эхэлсэн ч эрх чөлөөтэй ажиллах орчин хомс хэвээр байсан. Учир нь төрийн оролцоог хуулиар хориглосон ч хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздээс болон санхүүжигч байгууллагаас хараат байх боломж хэвээр байв.

2005 онд олон нийтийн радио телевизийн тухай хуулийг баталсан. Уг хуульд “Олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакц Үндсэн хууль болон энэ хуулийн үзэл санаанд нийцсэн

нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, олон нийтийн радио, телевизийн удирдлага хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно” гэж заасан байдаг².

Технологийн хурдацтай өөрчлөлтийн нөлөөгөөр цахим сэтгүүл зүй шинээр үүсэж, мэдээний сайтууд тогтмол үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь хэвлэл мэдээллийн салбарын бүтцэд томоохон өөрчлөлт орох нөхцөл бүрдсэн юм. Тухайн үед Монгол Улсын хэмжээнд 383 хэвлэл мэдээллийн хэрэгсэл байсан бол өдгөө 502 болж өсжээ³.

2011 онд Мэдээллийн ил тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 онд баталсан нь мэдээллийг ил тод болгох эрх зүйн суурийг тавьсан. Хэдийгээр дээрх хуулиудын үр дүнд иргэн бүр өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөтэй болсон ч хэвлэл мэдээлэл бүрэн утгаар бие даасан, хараат бус байж чадаагүй хэвээр байна. Тухайлбал, 2020 оны сонгуулийн сурталчилгааны 70-80 хувь нь далд, худал сурталчилгаа байв⁴. Хэвлэл мэдээллийн чиг хандлага болсон олон нийтийн сүлжээ нь цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх талбар болж, сэтгүүлчдийн ажиллах арга барилд цоо шинэ өөрчлөлтийг авчирсан. Үүнийгээ дагаад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хариуцлага, ёс зүйн асуудал хөндөгдөж байна.

2020 оны байдлаар Монголын хэвлэл мэдээллийн салбарт 4700 орчим хүн ажиллаж байна⁵. Монголын зах зээл харьцангуй жижиг учир хэвлэл мэдээллийн салбар зах зээлийн зарчмаараа үйл ажиллагаа нь явдаггүй. Санхүүгийн шалтгааны улмаас аль нэг нам, эрх бүхий байгууллага, хүмүүсийн харьяанд үйл ажиллагаа явуулах нь элбэг. Тухайлбал, 2019 онд томоохон хэвлэл мэдээллийн байгууллагын 70-аас илүү хувь улс төрийн өндөр албан тушаалтны эзэмшлийнх байсан тухай Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн судалгаанд дурджээ⁶.

Ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хангахаар олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо чөлөө илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх суурь эрхээ батлуулсан. Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд НҮБ-аас тунхагласан бусад эрх, эрх чөлөөг хэмжих үндсэн хэмжүүр⁷ гэж 1948 оны Ерөнхий Ассамблейн чуулганаар тунхагласан байдаг. Монгол улс нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд нэгдсэнээр иргэд мэдээлэл хүлээн авах, үзэл бодлоо илэрхийлэх, халдашгүй чөлөөтэй байх эрхээ баталгаажуулсан.

² Олон нийтийн радио, телевизийн тухай хууль (2002) - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2005 №8 (389)

³ “Монголын хэвлэл мэдээлэл 20 жилд” (2020) Хэвлэлийн Хүрээлэн

⁴ Сонгууль ба мэдээллийн төөрөгдөл, (2020), Хэвлэлийн хүрээлэн

⁵ Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр” тайлан, (2020), Хэвлэлийн хүрээлэн

⁶ Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр” тайлан, (2019), Хэвлэлийн хүрээлэн

⁷ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн анхдугаар чуулга уулзалтын 59-р тогтоол (1948)



1.2 Сэтгүүл зүйн салбарт тулгамдаж буй асуудлууд

Хараат бус, мэргэжлийн сэтгүүл зүй нь олон нийтийг бодит мэдээллээр хангах, эрүүл мэндийн зохистой арга хэмжээний талаар таниулан сурталчлах, хуурамч мэдээллийг сааруулах, асуудал дэвшүүлэх, төр засгаас хариуцлага нэхэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Хил хязгааргүй сурвалжлагчид байгууллагаас нэгтгэн гаргадаг 2020 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексэд дэлхийн 180 улсаас Монгол улс 73-т оржээ⁸.

Парламентад сөрөг хүчний нөлөө бага, улс төрийн нөхцөл байдал тогтворгүй үед хэвлэл мэдээлэл нь нийгмийн дуу хоолой болж, дөрөв дахь засаглалын үүргийг гүйцэтгэх учиртай. Харамсалтай нь хэвлэл мэдээллийг боомилох, сэтгүүлчдийн эрхэнд сөргөөр нөлөөлөх хууль журмууд сүүлийн жилүүдэд батлагдсан нь хэвлэлийн эрх чөлөөнд халдсан хэрэг болсон. Жишээ нь 2016 онд “Төрийн ба албаны нууцын тухай хууль” шинээр батлагдаж, 2017 оноос мөрдөгдөж эхэлсэн. Уг хуулийн дагуу Үндсэн хуульд заасан “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заан нийтийн мэдэх эрхийг баталгаажуулсан байдаг ч энэхүү нууцын хууль нь аль нэг албан тушаалтан шийдвэр гаргаж төрийн эсвэл албаны нууц гэж мэдээллийг хязгаарлах боломж бүрдсэн.

Өөрөөр хэлбэл, энэхүү хууль нь хэвлэл мэдээллийн эрх зүйн орчныг боомилсон, сэтгүүлчдийг нууц задруулсан гэж шийтгэл оногдуулах эрх зүйн нөхцөл бүрдэхэд хүргэсэн. Үр дүнд нь 2004-2017 он хүртэл 14 жилийн хугацаанд ердөө 60 мэдээлэл төрийн нууцад хамаарч байсан бол 2017-2019 онд 565 болж огцом өссөн⁹.

Мөн 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулиар бусдыг гүтгэсэн иргэнийг 2 сая, хуулийн этгээдийг 20 сая төгрөгөөр торгохоор заасан. Тухайн үед Зөрчлийн тухай хуулийг УИХ хэлэлцэж байх үед хэвлэл мэдээллийн хэрэгслийг боомилох заалт орсонд эгдүүцсэн хэвлэлийнхэн нэгдэж тэмцэж байсан.

Өдөр тутмын сонинууд нүүрээ харлуулж, өргөн нэвтрүүлгийн телевизүүд эсэргүүцлээ илэрхийлэн эфирээ хаан, түгшүүрийн дохио дуугаргасан. Зөрчлийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2019 он хүртэл “Гүтгэх” заалтаар 355 зөрчил бүртгэгдсэн байна¹⁰. Харин 2020 оны 1-р сараас Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болж, Зөрчлийн хуулийн “гүтгэлэг” гэх заалт хүчингүй болсон.

Эрүүгийн хуулийн 14.8.1-т сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэрэгт илт худал мэдээлэл тараасан бол мөнгөн дүнгээр торгох, нийтэд тустай ажил хийлгэх эсвэл нэг сараас нэг жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах тухай заасан байдаг¹¹. Харин 2020 оны 12-р сарын 8-ны өдөр Хууль

⁸ Глоб Интернэшл (2019) Хэвлэлийн эрх чөлөөний тайлан

⁹ Глоб Интернэшл (2019) Хэвлэлийн эрх чөлөөний тайлан

¹⁰ Глоб Интернэшл (2019) Хэвлэлийн эрх чөлөөний тайлан

¹¹ Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга) – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2016 он №07 (916)

зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайт дээр байршуулсан “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” баримт бичгийн төсөлд дээрх сонгуульд оролцогч улс төрийн нам, намын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж үйлдсэн бол зургаан сараас нэг жил хүртэл хорих ялаар шийтгэх заалтыг нэмсэн байна.

Мөн хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдаж гутаах, эсхүл олон нийтийг төөрөгдүүлэх, эсвэл айдаст автуулах зорилгоор хортой, илтэд худал мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн мэдээллийн сүлжээний хэрэгсэл ашиглан тараасан, эсхүл илтэд худал мэдээлэл болохыг мэдсээр байж түгээсэн бол мөнгөн торгууль ногдуулах, эсхүл нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зорчих эрхийг хязгаарлах шийтгэл ногдуулах ба гэмт хэрэг нь зохион байгуулалттай, улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулж үйлдсэн бол мөнгөн торгууль, эсхүл зорчих эрх хязгаарлах, эсхүл нэгээс таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заажээ. Эдгээр заалт нь сэтгүүлчид болон иргэдийн үзэл бодлыг хязгаарлах, цензур тогтооход хүргэх эрсдэлтэй.

“Хэвлэлийн хүрээлэнгийн Мэдээллийн төвийн менежер Д.Доржхоролын редакцын хараат бус байдлын асуудлаар сэтгүүлчдийн дунд хийсэн тандалт судалгаанд нийт сэтгүүлчдийн 50 хувь нь буюу 2 сэтгүүлч тутмын нэг нь хараат бус үйл ажиллагаа явуулж чаддаггүй, 54.5 хувь өөрийн бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгээ чөлөөтэй нийтэлж нэвтрүүлж чаддаггүй, 46.3 хувь нь ХМХ-ийн эрхлэгч, редакторууд сурвалжлагч, ажилтнуудынхаа өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжлийн шаардлага, хяналт тавьж редакцын хараат бус байдалд халддаг, 39 хувь нь бэлтгэсэн материалаа тухайн байгууллагын тодорхой бодлогын үүднээс нийтэлдэггүй, зарим хэсгийн хасдаг гэжээ¹².

Глоб Интернэшл төвийн судалснаар 2019 оны 5-р сараас 2020 оны 5-р сар хүртэлх хугацаанд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой нийт 274 мэргэжлийн зөрчил бүртгэгдсэн байна¹³. Энэ нь зөвхөн бүртгэгдсэн тоо бөгөөд эрх нь зөрчигдсөн олон сэтгүүлч, редакц зөрчлийн талаар мэдээлэхийг хүсдэггүй аж. Тус төвөөс тусламж, зөвлөгөө авахаар нийт 30 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага хандсаны дийлэнх хувьд эрх зүйн зөвлөгөө авахаар ханддаг байна. Тухайлбал цагдаа, прокурор болон шүүхтэй холбоотойгоор 14 хүн, сүрдүүлэг, заналхийлэл, дарамтлахтай холбоотой 6 хүн, мэдээлэл авахад саад учруулсан, хөдөлмөрлөх эрхэд халдсан, биед халдсан зэргээр 9 хүн тус төвд ханджээ.

¹² Д.Доржхорол ”Редакцын хараат бус байдлын асуудлаар сэтгүүлчдийн дунд хийсэн тандалт судалгаа”(2008)

¹³ Глоб интернэшл ТББ-ын судалгаа (2020 оны 5 сар)

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрхэд халдсан 274 зөрчлийг ангилбал:



Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхэд халдсан нийт зөрчлийн дийлэнх хувийг “мэдээлэл өгөхөөс татгалзсан буюу мэдээлэл олж авах, түгээхэд саад хийсэн”- 25%, “Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан”-17%, “Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан”-16% эзэлж байна. Мөн судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 51.2%-ыг нууц эх сурвалжаа илчлэхийг албадаж байсан¹⁴.

Сэтгүүлчийн бусдаас хараат бус байх явдал нь эрх чөлөөний асуудал боловч уг эрх чөлөөг хуульчлан баталгаажуулаагүй бол тунхаглал төдий зүйл болно. Хараат бус байдал нь хуулиар хамгаалагдаагүй сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад төрөл бүрийн дарамт шахалтад орж мэргэжлийн үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрнэ. Иймд сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах үндсэн нөхцөл нь хуулиар эрхээ хамгаалуулах явдал юм. Олон улсын практикт сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах хамгаалах чиглэлээр хууль батлан хэрэгжүүлдэг олон сайн жишээ байна. Үүнтэй холбоотой асуудлыг дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн тухай сэдвийн хүрээнд ёс зүйн тухай асуудлыг заавал хамааруулан үздэг байна. Сэтгүүлчийн хараат бус байдлыг хуулиар хамгаалахын зэрэгцээ тэдний мэргэжлийн ёс зүйг сэтгүүлчдийн бие даасан байгууллагаас дүрэм, журам гарган дотоод зохицуулалтын хүрээнд батлан гаргадаг. Мэргэжлийн ёс зүйн код нь чөлөөт, хараат бус, хариуцлагатай сэтгүүл зүйг хөгжүүлэх тулгуур болдог¹⁵.

¹⁴ Глоб интернэшнл ТББ-ын судалгаа (2020 оны 5 сар)

¹⁵ Глоб Интернэшл (2019) Хэвлэлийн эрх чөлөөний тайлан

1.3 Сэтгүүл зүйн хараат бус байдлын тухай ойлголт

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь эрх төдийгүй ардчилсан нийгмийн үндсэн шалгуур үзүүлэлт болдог. Иймээс хэвлэл мэдээллийн эрх чөлөөгүйгээр ардчилсан нийгэм оршин тогтнохгүй гэдгийг хүний эрхийн олон зүтгэлтнүүд өөрсдийн бүтээлдээ дурдсан байдаг. Жишээлбэл, Ардчиллын төлөө цогтой тэмцэгч, Америкийн XVI ерөнхийлөгч Абрахам Линкольн “өөрийнхөө дайсныг хүртэл чөлөөт хэвлэлтэй байхын төлөө амь насаа зориулахад бэлэн байна” гэж уриалж байсан.

“Сэтгүүлчдийг мөрдөж мөшгөхөд нийгэм бүхэлдээ хор хохирол амсдаг. Тэднийг зохистой хамгаалж чадахгүй аваас бидний мэдээлэлтэй байх, шийдвэр гаргах явцад оролцох боломж хумигдан боогдоно. Сэтгүүлчид аюулгүй нөхцөлд ажлаа хийх боломжгүй бол бид хуурамч мэдээлэл, самууралд автах болно.”¹⁶ НҮБ-ын анхны Ерөнхий нарийн бичгийн дарга Антониу Гутерриш хэлжээ.

Ардчилсан нийгмийн тулгуур эрхийн нэг нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, олж авах, түгээх зэрэг эрхийг өөртөө багтаасан хэвлэл мэдээллийн эрх чөлөө юм. Учир нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө иргэдэд Засгийн газрын шийдвэр гаргах процесст хууль ёсны эрх ашгаа хамгаалан оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, шүүмжлэх зэргээр бодлого боловсруулах үйл ажиллагаанд нөлөөлөх, зөрчигдсөн эрхээ сэргээх боломж олгодог.

Хараат бус хэвлэл гэдэг нь улс төр, эдийн засгийн хувьд бие даасан, сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахдаа редакцаас чөлөөтэй эрхлэх боломжоор хангагдсан хууль эрх зүйн орчин бүрдсэн байхыг ойлгодог.

Монгол Улс 2020 онд хэвлэлийн эрх чөлөөний индексээр “Хагас эрх чөлөөтэй” орны тоонд багтаж байгаа нь чөлөөт хэвлэл төлөвшөөгүй, сэтгүүлчид хараат бусаар үйл ажиллагаагаа эрхэлж чадахгүй байгаагийн илрэл юм.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь сэтгүүлчид үйл ажиллагаагаа явуулахдаа бие даасан хараат бус байдлаар эрхлэн явуулах боломж бүрдсэн тохиолдолд л хэрэгждэг. Иймээс сэтгүүл зүйн салбарт сэтгүүлчийн хараат бус байдал хэрхэн хангагдсан талаар судлах явдал нь судалгааны ажлын хүрээнд нэн тэргүүнд тавигдаж байна. Учир нь энэ чиглэлээр дагнан хийгдсэн судалгааны ажил хараахан гараагүй байна. Харин уг асуудал нь зарим судалгааны байгууллагуудаас хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хүрээнд хийгдсэн судалгааны ажлын хүрээнд цухас дурдагдаж байгаагаас үзвэл сэтгүүлчийн хараат бус байдлыг эрх зүй, эдийн засаг, улс төр, мэргэжлийн үүднээс зэрэг тал бүрээс нь авч үзэж судлах явдал нь онолын хийгээд практик ач холбогдолтой болохыг харуулж байна.

“Монгол хэлний тайлбар толь”-д “Хараат” гэдэг үгийг “харьяат, бусдын эрхшээлд байх,”¹⁷ хэмээн тайлбарлажээ. Үүнээс үзвэл “хараат бус” гэдэг нь эрхшээлээс ангид биеэ даасан байхыг ойлгоно.

¹⁶Глоб Интернэшнл ТББ -ны нийтэлсэн нийтлэл (2020 он 12 сар)

¹⁷ Я. Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь", 662-р тал

Олон улсын сэтгүүлчдийн холбооноос “Хараат бус хэвлэл, мэдээллийн хэрэгсэл гэдэг нь Засгийн газар, улс төрийн болон эдийн засгийн хяналтаас хараат бус, мөн шаардлагатай үндсэн эд материалын болон дэд бүтцийн эрхшээлээс хараат бус байх явдал гэж үзнэ”¹⁸ хэмээн томъёолжээ.

Олон улсын сэтгүүлчдийн холбооны гол баримт бичигт “Хэрвээ сэтгүүлчид авлига, ядуу зүдүү байдал, айдас хүйдсийн нөхцөлд байвал тэнд хэвлэлийн эрх чөлөө байхгүй”¹⁹ хэмээн онцолсон. “Сэтгүүлзүйн тайлбар толь”-д тэмдэглэсэнээр “Чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг нь төр засгаас хараат бус, эдийн засгийн хувьд бүрэн бие даасан, улс төрийн байгууллын харьяалалгүй, ил тод байдал олон ургалч үзлийн чөлөөт индэр болсон байхыг ойлгоно...”²⁰ гэсэн байна.

Чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол шалгуурыг дараах байдлаар авч үзжээ. Үүнд:

- 1/ эдийн засгийн хувьд бүрэн бие даасан
- 2/ статусын хувьд бүрэн бие даасан
- 3/ төр, засгийн хараат бус
- 4/ улс төрийн намын харьяалалгүй
- 5/ улс төрийн бодлогоос ангид
- 6/ ил тод байдал, олон ургалч үзлийн индэр болсон
- 7/ нийгэм улс төрийн нийтлэг хэвлэлийн тодорхой хүрээнд үйлчилдэг
- 8/ хууль тогтоомжийн хязгаарлалтгүй, чөлөөтэй байх
- 9/ төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар “сөрөг хүчний” үүргийг гүйцэтгэж чадахуйц байх нь жинхэнэ чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл мөн хэмээн онцолсон байна.

Дүгнэн үзвэл хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэдэг нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээллийг бусад этгээдийн хяналтгүйгээр зөвхөн мэргэжлийн ёс зүйд тулгуурлан үнэн бодитойгоор олон нийтэд түгээх үйл ажиллагаа гэж үзэж болохоор байна. Гэвч энэ нь дангаараа хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хэрэгжүүлэх үндсэн баталгаа болж чадахгүй юм. Учир нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хуульчлан хамгаалахгүй бол дүр эсгэсэн хэвлэлийн эрх чөлөөнд хүргэнэ. Иймд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг төрөөс хуульчлан баталгаажуулах нь ардчилсан төрт улсын нэн тэргүүний үүрэг юм.

Сэтгүүлчийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийг гадаад, дотоод гэсэн хоёр үндсэн хэсэгт ангилан авч үзэж болно. Үүний зэрэгцээгээр хэвлэл мэдээллийн дотоод зохицуулалт “хүлээн зөвшөөрөгдсөн байх” өөрөөр хэлбэл, сэтгүүлчийн хараат бус байдал хуульчлагдсан байхын зэрэгцээ өөрийн мэргэжлийн холбооноос гаргасан дүрэм журам мөрдөгдөг байх шалгуур байдаг.²¹

1.4 Сэтгүүлчийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлдөг гадаад хүчин зүйл

¹⁸“Хүний эрхийн түгээмэл тунхаглал” АНУ-ын ЭСЯ, Глоб интернэшнл ТББ \УБ2008\ 82-р тал

¹⁹ Глобын сонин бичиг №9 УБ 2007 тал, 10 дугаар тал

²⁰“Сэтгүүл зүйн тайлбар толь” М.Зулькафиль УБ 2005, 250-р тал

²¹ 4 Self regulation. http://www.osce.org/publications/rfm/2008/04/30697_1117_en.pdf

Сэтгүүлчийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлдөг гадаад хүчин зүйлд улс төр, үзэл суртлын нөлөөллөөс хараат бус байх, мэдээллийн эх сурвалжаас хараат бус байх, санхүүгийн эх үүсвэрээс хараат бус байх, үйл ажиллагаа нь шууд уялдах дэд бүтцээс хараат бус байх, эздээс хараат бус байх зэрэг нөхцөлүүд хамаардаг. Мөн түүнчлэн сэтгүүлчийн эрэн сурвалжлах үйл ажиллагааны эрх зүйн хамгаалалт, төрийн байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах эрх, эх сурвалжаа нууцлах эрхийн хамгаалалт, редакцаас хараат бус байдал, сэтгүүлчид нөлөөлсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зэрэг бүлэг асуудлууд багтдаг.

1. Улс төр, үзэл суртлын нөлөөллөөс хараат байдал

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төр, үзэл суртлын нөлөөллөөс ангид байлгахын тулд нэн тэргүүнд хэвлэл мэдээллийн эрх чөлөө хэрэгжих эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай. Үүний зэрэгцээ улс төрчдийн ёс зүй, соёл, ардчилсан нийгэм байгуулах чин хүсэл эрмэлзэл, хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлагын соёл, ардчилсан сэтгүүлзүйн тухай ойлголт, мэдлэг боловсрол, сэтгүүлчдийн өөрсдийн боловсрол, мэргэжлийн үүргийн тухай ойлголт зэрэг нь улс төрийн нөлөөллөөс ангид сэтгүүлзүйг хөгжүүлэхэд нэлээд нөлөөтэй юм.

Түүнчлэн хэвлэлийн эрх чөлөө нь мэдээлэл түгээгчид маш их боломж олгодог. Улс төрийн намын харьяалалгүй үйл ажиллагаагаа явуулах нь сэтгүүлч мэргэжлийн нэг онцлог юм. Учир нь аливаа улс төрийн намын зорилго нь төрийн эрхийг дангаар авахад оршдог. Улс төрчдөөс ангид байж ил тод байдал, олон ургалч үзлийн индэр болох сэтгүүлчийн олон нийтийн төлөө үйлчлэх үүрэгтэй ямагт зөрчилддөг.

Иймд сэтгүүлч улс төрийн намын гишүүнчлэлээс татгалзах, аливаа улс төрийн бодлогоос ангид үйл ажиллагаагаа эрхлэн явуулах нь түүний хараат бус байдалд эерэгээр нөлөөлдөг тул хуулиар зарим сэтгүүлчдэд улс төрийн аливаа гишүүнчлэлтэй байхыг хориглодог.²²

2. Мэдээллийн эх сурвалжаас хараат байдал

Хэвлэл мэдээллийн байгууллага нь үйл ажиллагааны мөн чанарын хувьд эх сурвалжаас байнга хамаарч байдаг. Олон нийтийг бодитой, тэнцвэртэй мэдээллээр хангахын тулд сэтгүүлч заавал ямар нэгэн эх сурвалжаас мэдээлэл авна. Зөрчилтэй мэдээллийг нуун дарах эрмэлзэл, төрийн байгууллагын хүнд суртал, эрх мэдэлтэн болон арилжааны томоохон компаниуд өөрсдийнхөө тухай зөвхөн эерэг мэдээлэл түгээх сонирхол зэрэг нь мэдээлэл авах боломжийг хүндрүүлж, эх сурвалжаас хараат байдлыг бий болгодог.

Нийгмийн амьдралын гүнд орж, өдөр бүр янз бүрийн хүнтэй учирч, олон үйл явдлын гэрч болж буй сэтгүүлч хүн эх сурвалжийнхаа найдвартай эсэхийг хянах, нөгөө талаар тухайн мэдээллийн

²² Олон нийтийн радио телевизийн тухай хууль, 4,21,31 дүгээр зүйл- “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2005 №8 (389)

бодитой эсэхийг нягтлах үндсэн үүрэгтэй. Тухайлбал, төрийн байгууллагын ажилтны мэдээлэл өгөх үүрэг, сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх зэргийг хуульчлан баталгаажуулдаг²³.

Түүнчлэн зарим улс орнуудад сэтгүүлч мэдээлэл олж авах эрхийг хуульчилдаг.²⁴

3. Эдийн засгийн хараат бус байдал

Эдийн засгийн хараат бус байдал нь сэтгүүлч болон редакц эдийн засгийн хувьд бүрэн бие даасан, өөрийн өмч хөрөнгө, ажлын байр, хөдөлмөрийн хөлсөө бие даан санхүүжүүлж чаддаг байх санхүүгийн олон эх үүсвэртэй байх, статусын хувьд бүрэн бие даасан, төр, засгийн газраас хараат бус үйл ажиллагаагаа эрхлэн явуулахыг тус тус ойлгодог.

Зар сурталчилгааны орлогын эх үүсвэрээс хараат байх нөхцөлийг бүрдүүлэх нь хамгийн чухал юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бодит тэнцвэртэй мэдээллээр олон нийтэд үйлчлэх үүрэгтэй боловч орлого олж ашигтай ажиллах зах зээлийн зарчим үйлчилж байдаг. Тиймээс зах зээлд оршин тогтнохын тулд далд сурталчилгаа явуулах аргаар орлого олох, зар сурталчилгаа өгдөг томоохон түнш байгууллагын талаар шүүмжлэлт мэдээлэл хийхээс татгалзах гэх мэт сөрөг үр дагавар байнга илэрдэг гэж болно. Үүнээс зайлсхийхийн тулд дараах зохицуулалтыг хийж болдог ажээ. Үүнд:

- Далд сурталчилгааг хориглох, ивээн тэтгэлэгт нийтлэл, нэвтрүүлгийг хязгаарлах буюу хатуу дүрэм журмын дагуу явуулах, эрх зүйн зохицуулалт хийх,
- Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын нэг хэсэг болох редакцын дүрэм, ёс зүйн зарчим бий болгож мөрдөх гэх мэт.

4. Үйл ажиллагаатай шууд уялдах дэд бүтцээс хараат байдал

Шуудан холбооны дэд бүтэц, түгээлтийн системийн гажуудал, хэвлэлтийн зардал өндөр байх, цацах станц гэх мэт хүчин зүйлүүдийн доголдол нь эдийн засгийн хараат байдалд ороход түлхэц болж байдаг. Мөн үүнд тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын бүтэц, шийдвэр гаргах шат дараалал, байгууллагын соёл, удирдлагын арга барил ч бас нөлөөлдөг ажээ.

Манай улсын хувьд түгээлтийн боловсронгуй систем байхгүйгээс үүдээд хэрэглэгчдэд сонголт хязгаарлагдмал, орон нутагт сонин хэвлэлээ хүргэх бүтэц хязгаарлагдмал байна.

5. Эздээс хараат байдал

МУБИС-ийн сэтгүүлзүйн багш, доктор \Ph.D\ М.Одмандах “Орчин цагийн сэтгүүл зүй ба хараат бус байдал” өгүүлэлдээ “Манай чөлөөт хэвлэл өнөөдөр чөлөөт хэвлэл мэдээллийн гол шалгуурыг хангахгүй байгаа нь хэнд ч илт тодорхой болжээ. Монголын чөлөөт хэвлэлийн хувьд эзнээс хараат бус байдал алдагдсан. Энэ нь сэтгүүлч, ажилтны шударга, үнэнч ажиллах зарчимд

²³ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2011 №26 (695)

²⁴ Гүржийн Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах тухай хууль үзнэ үү.

нөлөөлж буй томоохон бодит хүчин зүйл мөн. Хараат бус хэвлэл мэдээллийн орчныг бүрдүүлэхдээ хэвлэл мэдээллийн хараат бус байх төрийн болон эрх зүйн орчныг судлах, эдийн засгийн орчин, ёс зүйн хариуцлагын тогтолцоог оновчтой бүрдүүлэх, редакцын ардчиллын байдлыг баталгаажуулах”²⁵ гэх мэт арга замууд байгааг дурдсан байдаг. Засгийн газрын шууд цензур байдаггүй боловч нууц эх сурвалжаа илчлэхийг хууль хяналтын байгууллагын зүгээс шаардах, дарамтлах, айлган сүрдүүлэх явдал гарч байгааг сэтгүүлчид шүүмжилсээр байгаа.

2007 онд ЮНЕСКО-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын хэвлэл мэдээллийн салбарын төлөв байдал” төслийг “Монголын хэвлэлийн хүрээлэн” ТББ, “Глоб интернэшнл” ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн юм. Төслийн хүрээнд Дани, Их Британийн шинжээчид Монголын хэвлэл мэдээллийн байдалд дүгнэлт өгсөн. Тус тайлангийн дүгнэлтэд “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бизнес мэдээ төлбөрт нэвтрүүлгээр дүүрчээ. Үүнийг санхүүгийн бэрхшээлтэй салбараа өөд татах боломж гэж үзэж буй нөхцөлд ХМХ, сэтгүүлчид нь улс төр, бизнесийн санхүүгийн дэмжлэгээс туйлын хараат болсныг харуулж байна.

Ашиг орлоготой хэвлэл мэдээллийн бизнес байх нь ховор, харин улс төр бизнесийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьж, тэдэнд үйлчилдэг суртал ухуулгын дуу хоолой болжээ. ХМХ-ийн өмчлөлийн хэлбэр, ил тод байдал хангалтгүй, жинхэнэ эзнийг мэдэх аргагүй, ар талд нь гол төлөв улс төр, бизнесийн ашиг сонирхол үйлчилж байдаг... хэмээн тодорхойлжээ. Тус тайланд мөн өнөөгийн байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөл бага байна. Хувийн хэд хэдэн мэдээллийн хэрэгсэл нэгдэн нийлсэн давамгайлах байр суурь алга. Орон нутгийн хэвлэл мэдээлэлд аймгийн дарга нар давамгайлах байр суурь гүйцэтгэдэг аж. Мэдээллийн эрх чөлөөний асуудал ихээхэн сэтгэл түгшээж байна хэмээн онцолж байжээ²⁶. Эл байдал өнөөдөр ч манай хэвлэл мэдээллийн салбарт байсаар байна.

Сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах дотоод хүчин зүйл

Сэтгүүлчийн хараат бус байдалд нөлөөлдөг нэг хүчин зүйл нь дотоод хүчин зүйл юм. Өөрөөр хэлбэл, сэтгүүлч мэдээлэл олж авах, боловсруулах, түгээх бүхий л үйл ажиллагаанд редакц болон хамтран ажиллаж буй баг хамт олноос хараат бус байх явдал чухал байр суурь эзэлдэг. Өөрөөр хэлбэл, редакц болон хамтран ажиллаж буй баг хамт олноос хэвлэн нийтлэх мэдээ мэдээллийн агуулгад өөрчлөлт оруулах, олон нийтэд хүргэхгүй байх зэргээр сөргөөр нөлөөлөх, сэтгүүлчийн бие даасан ажиллагаанд саад учруулах нь сэтгүүлчийн хараат бус байдалд буруугаар нөлөөлж байгаагийн нэг хэлбэр юм.

Сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахдаа эрх чөлөөтэй, хараат бус ажилласнаар олон нийтийн мэдэх эрхэд шударгаар үйлчлэх таатай нөхцөл боломж бүрддэг. Иймд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь сэтгүүлчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй зөвхөн ёс зүйн хийгээд мэргэжлийн үүднээс л шаардлага тавьж байх нь сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах нэг

²⁵ М.Одмандах “Орчин цагийн сэтгүүл зүй ба хараат бус байдал” Сэтгүүлч сэтгүүл № 01\24\, УБ 2006

²⁶ ЮНЕСКО “Монголын хэвлэл мэдээллийн салбарын төлөв байдал” Улаанбаатар хот 2007 он



нөхцөл юм. Практикт нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад цензур тавих, өөрт нь хамааралгүй нийтлэл, нэвтрүүлэгт сэтгүүлчийн нэрийг ашиглахаар санал болгох, сэтгүүлчдийн хүсэл зоригийн эсрэг нийтлэл бичих, нэвтрүүлэг хийхийг даалгах зэрэг тохиолдлууд ихээхэн гардаг.

Иймд ардчилал өндөр хөгжсөн орнуудад дээрх үйлдлүүдийг хийхийг хуульчлан хориглосон байдаг.

Редакцаас хараат бус байх

МУБИС-ын сэтгүүлзүйн багш М.Одмандах “Редакцын хараат бус байдлыг баталгаажуулах нэг боломж нь сонины эзэн, эрхлэгч буюу ажил олгогч, ажилтан сэтгүүлч нарын хооронд байгуулах хөдөлмөрийн гэрээ хэмээн онцолсон байна. “Сэтгүүлч хүн улс төр, эдийн засгаас хараат бус байхын зэрэгцээ эзэмшигч удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай”²⁷.

Гэхдээ ихэнх оронд өөрийн дотоод зохицуулалтаар хянадаг. Хараат бус байдал нь сэтгүүлчийн үнэт зүйл. Хараат бус байж л үнэнийг хэлж чадна. Хараат бус байдал хэдий чинээ алдагдана, үнэт зүйл нь байхгүй болно.

Судлаачид редакцын хяналт нь цензурин далд хэлбэрт хамаарах бөгөөд бэлтгэсэн мэдээ, мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхгүй байх, зарим хэсгийг хасч танах, өөрчлөхийг өрөөсгөл ашиг сонирхлын үүднээс шаардах, тулгах зэрэг үйлдлээр илрэн гардаг гэж үздэг. Хэрэв энэ тулгалтыг биелүүлэхгүй бол сэтгүүлчийг ажлаас халах, цалин хөлсийг нь хасах, загнах, доромжлох явдал практикт түгээмэл тохиолддог. Үүнд:

1. Нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод цензур тавих
2. Нийтлэл, нэвтрүүлэгт сэтгүүлчийн нэрийг ашиглах
3. Сэтгүүлчдийн хүсэл зоригийн эсрэг нийтлэл бичих, нэвтрүүлэг хийх даалгавар өгөх
4. Бэлтгэсэн материалыг тодорхой зорилгоор нийтлэхгүй, нэвтрүүлэхгүй байх зэрэг.

Сэтгүүлчийн хараат бус байдалд нөлөөлдөг нэг хүчин зүйл нь редакцын хараат бус байдал юм. Хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогыг улс төр, эдийн засгийн хөндлөнгийн нөлөөллөөс хараат бус, бие даасан байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэх эрх мэдэлтэй байх ёстой.

Дотоод хүчин зүйлд эзэмшигч, эрхлэн гаргагч болон удирдлагын арга барил, байгууллагын соёл, бүтэц, зохион байгуулалтыг хамруулж болно. Өөрөөр хэлбэл, гаднын нөхцөл байдал ямар байхаас үл хамаарч тухайн хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн дотоод ардчиллыг хэрхэн бий болгож буйг тодорхойлно.

²⁷ М.Одмандах “Орчин цагийн сэтгүүл зүй ба хараат бус байдал” Сэтгүүлч сэтгүүл № 01\24\, УБ 2006

Нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, үйл ажиллагааг зөвхөн мэргэжлийн ёс зүй бусад шаардлагын дагуу бие даасан байдлаар явуулах нь хараат бус, төвийг сахисан сэтгүүл зүйн хэрэгслийн үндсэн нөхцөл болох ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үзэл суртал, ухуулга сурталчилгааны хэрэгсэл болохоос зайлсхийх боломжийг нээдэг.

1.5 Дэлхий нийтийн хандлага /туршлага/

Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд “хоточ нохойн” үүргээ гүйцэтгэх ёстой. Үүний тулд редакцын хараат бус байдал маш чухал. Өөрөөр хэлбэл, сэтгүүлчдэд улс төр, эдийн засгийн аливаа дарамт шахалтгүйгээр үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжийг олгосноор ардчиллын үнэ цэнийг хадгалах боломжтой. НҮБ-ын үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах, түгээх тухай 2016 оны 9-р сард гаргасан зөвлөмжид засгийн газрууд хараат бус сэтгүүл зүйг хүндлэхээс гадна сэтгүүлчид, тэдгээрийн мэдээллийн эх сурвалжийг хууль эрх зүйн хүрээнд хатуу хамгаалах ёстойг онцолсон байв.

Улс орнууд олон талт мэдээлэл, үзэл бодлыг нийгэмд түгээх, хараат бус сэтгүүл зүйг хөгжүүлэх, сэтгүүлчдийг хамгаалах зорилготойгоор хууль тогтоомжуудыг хэрэгжүүлж байна.

Үүний томоохон жишээ бол Европын Зөвлөлөөс гаргасан Хүний эрхийг хамгаалах тунхаг юм. Уг тунхагт гишүүн орнууд сэтгүүлчдийг эдийн засгийн болон улс төрийн нөлөөнөөс ангид, хараат бусаар ажиллах механизмыг бүрдүүлэх ёстойг заажээ.²⁸

Мөн сэтгүүлчдэд ирэх дарамт шахалтыг гадаад, дотоод гэж ангилах бөгөөд Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуульд сэтгүүлчийн өдөр тутмын ажилд хөндлөнгөөс оролцож, нөлөөлөх боломж (дотоод дарамт, шахалт)-ийг хаасан байхаар зохицуулахыг тусгасан.

Түүнчлэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажиллах боловсон хүчний асуудлыг мерит зарчмыг үндэслэн шийдвэрлэнэ гэсэн байдаг. (Энэ бол өнөөдөр удирдлагын халаа, сэлгээний асуудлаас болоод Үндэсний олон нийтийн радио, телевизэд нүүрлээд буй гол асуудал юм).

Бүгд найрамдах Македон Улс

Тус улсын Радио, телевизийн тухай хууль нь 8 бүлэг, 93 зүйлээс бүрдэнэ. Агуулгын хувьд редакцын хараат бус байдал болон радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг маш нарийн

²⁸ Европын Хүний эрхийн тунхаг, 10-р зүйл

зохицуулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг Харилцаа холбооны яам, Улсын мэргэжлийн хяналтын байгууллага болон Радио, телевизийн Зөвлөл хариуцан ажилладаг юм байна.

Улс төрийн нам, эвсэл болон бусад хувь хүний зорилгыг биелүүлэх үүднээс ажиллахгүй байх ёстой хэмээн заажээ. Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлд “аливаа программ, нэвтрүүлгийг ивээн тэтгэгч нь редакцын бие даасан, хараат бус байдал болон хариуцлагад нөлөөлөх замаар программ, нэвтрүүлгийн утга, үргэлжлэх хугацаанд нөлөөлөхгүй” байх хэрэгтэй хэмээн тусгажээ.

Оросын Холбооны Улс

Оросын холбооны улсын хувьд хэвлэл мэдээллийн харилцааг бүхэлд нь “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуулиар”²⁹ зохицуулдаг. Энэ хууль нь 62 зүйлээс бүрдэх бөгөөд хэвлэлийн эрх чөлөө, түүний бүтэц, сэтгүүлчдийн зөвлөл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тусгай зөвшөөрөл гэх мэт өргөн агуулга бүхий хууль байна. Тус хуулийн 3 дугаар зүйлд “Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд төрийн болон олон нийтийн байгууллага, бүлэглэл, бусад байгуулал, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хяналтын алба зэргээс аливаа цензур нөхцөл тогтоох, хэвлэх материалыг дэлгэрүүлэх, аливаа хэсгийг хасах зэргийг хориглоно”.

Мөн “Аливаа байгууллага, алба бусад байгууллагыг санхүүжүүлэхдээ олон нийтийн мэдээллийг цензурдэхыг хориглоно” гэжээ. Энэ хуулийн зохицуулалт нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг санхүүжүүлэгч, хамтран ажиллагсад болон байгууллагад зориулсан зохицуулалт бөгөөд редакцын эдийн засгийн хараат бус байдлыг баталгаажуулсан гэж болохоор байна.

Энэ хуулийн “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүсгэн байгуулагч хэмээх” 2 дугаар бүлгийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Үүсгэн байгуулагч нь энэ хууль, хяналтын албанаас гаргасан дүрэм, гэрээнд зааснаас бусад байдлаар мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно” хэмээн зохицуулжээ. Энэхүү заалт нь сэтгүүлч, редакц болон тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлагын хоорондын харилцааг зохицуулж, сэтгүүлчийн редакцын хараат бус байдлыг бий болгосон давуу талтай байна.

Дээрх зүйлээс гадна сэтгүүлч, редакцын хувийн эрх хэмжээг мөн хуулийн 47 дугаар зүйлд зохицуулсан бөгөөд 47 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “өөрийн итгэл, үнэмшилд нийцэхгүй мэдээ, мэдээллийг өөрийн нэрээр гаргахаас татгалзах”, мөн 11 дэх хэсэгт “өөрийн бэлтгэсэн мэдээ, мэдээлэлд ямар нэгэн байдлаар засвар орсон, бүлэг, хэсгийг хассан, хориглосон бол өөрийн нэрээр гаргахаас татгалзах эрхтэй” хэмээн хуульчилжээ.

Дээрх зүйлийн дагуу аливаа сэтгүүлч нь өөрийн тухайн мэдээллийг бэлтгэсэн анхны хүсэл, зоригт нийцээгүй, удирдлага болон бусад этгээдийн зүгээс их, бага хэмжээгээр засвар орсон, хассан, хувийн хараат бус, бие даасан байдалд халдсан хэмээн үзсэн бол тухайн мэдээ, нийтлэлийг өөрийн

²⁹ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_1511/

нэрээр гаргахаас татгалзах эрхтэй гэсэн байна. Энэ нь тухайн сэтгүүлч, редакц нь өөрийн итгэл, үнэмшилтэй байх, бие даасан, хараат бус байх нөхцөлийг хангаж өгчээ.

Европын Холбоо ба чөлөөт сэтгүүл зүй

Европын Холбооны Үндсэн хуульд гишүүн орнууд чөлөөт, олон ургалч сэтгүүл зүй хөгжих нөхцөлийг бүрдүүлж, хянах хараат бус механизмтай байх ёстойг заадаг. Европын Парламентын 2018 оны тавдугаар сарын 3-ны өдрийн хэвлэлийн эрх чөлөө, олон ургалч үзлийн тухай тогтоолд:³⁰



“Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүний үндсэн эрх бөгөөд ардчилсан нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, өөрийгөө хөгжүүлэхэд нь чухал нөлөөтэй. Энэ бол эрх зүйт нийгмийн салшгүй хэсэг. Ардчиллын суурь зарчим болох үг хэлэх эрхийн хүрээнд мэдээ, мэдээллийг хараат бусаар түгээх эрх нь олон ургалч сэтгүүл зүйн гол тулгуур” гэжээ.

Уг тогтоолд **“Засгийн газрын гишүүд эсвэл засгийн газартай холбоотой хувь хүн арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг өөрийн мэдэлд байлгах зэрэг нь чөлөөт, олон ургалч сэтгүүл зүйг үгүй хийдэг”** хэмээн онцолсон байв.

Мөн зарим тохиолдолд хэвлэл мэдээллийн салбарын ажилчид тодорхойгүй нөхцөлд ажиллах, шагнал, урамшуулал, хангамж зэргийг нарийн тусгаагүйгээс ажил үүрэгтээ хойрго хадах, улмаар чөлөөт сэтгүүл зүйд аюул учрах магадлалтайг дурджээ.

Европын Холбоо дан ганц өөрсдийн сэтгүүлчдэд анхаараад зогсохгүй холбооны газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн салбарын ажиллагсдыг ажил үүргээ

³⁰ Олон ургалч, чөлөөт хэвлэлийн тухай Европын Парламентын 2018 оны 5-р сарын 3-ны өдрийн тогтоол (2017/2209(INI))

чөлөөтэй гүйцэтгэх боломжоор хангахаас гадна сүрдүүлэх, хүч хэрэглэх, санхүүгийн болон улс төрийн аливаа дарамт шахалт үзүүлэх, эх сурвалжаа ил болгохыг шаардахыг хориглодог.

Сэтгүүлчдийн амь насыг хамгаалах тухай:

Европын Холбооны зарим гишүүн улс орнуудад үндэсний, популист үзэл баримтлалууд газар авснаар сэтгүүлчдэд ирэх дарамт шахалт нэмэгдэж, тэдний амь насанд занал хийх үзэгдэл их гарч байгаа нь харамсалтай. Олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилготойгоор улс төрчдийн хууль зөрчсөн үйлдлүүд, авлига, хүний эрхийн зөрчил, гэмт хэргийн тухай эрэн сурвалжилсныхаа төлөө сэтгүүлчид одоо ч гутаан доромжлогдож, сүрдүүлэгдэж, хүчинд автаж, цагдан хоригдон цаашлаад амиа алдсаар байна.

2017 оны 10-р сард авлигын гэмт хэргийг илчилснийхээ төлөө Малт улсад сэтгүүлч (Daphne Caruany Galizii – Европын Парламентын хэвлэлийн өрөөг түүний нэрээр нэрлэсэн бөгөөд эрэн сурвалжлах сэтгүүлчдэд жил бүр олгодог шагналыг түүний нэрэмжит болгожээ) амиа алдсан бол 2018 онд Словенийн эрэн сурвалжлах сэтгүүлч Jána Kuciaka сүйт бүсгүй Martiny Kušnírovej-н хамт гэртээ буудуулж нас барав.³¹ (ЮНЕСКО-ын мэдээлснээр ажил үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн сэтгүүлчдийн тоо 1500-д хүрчээ)³²

Үүний дараагаар Европын Парламентаас НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дэргэд сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хариуцсан төлөөлөгчтэй болох талаар гаргасан Хэл хязгааргүй сурвалжлагчид байгууллагын санаачилгыг бүрэн дэмжихийг гишүүн улс орнууддаа уриалсан юм.³³

Европын Холбоонд мөрдөгдөж байгаа онцлох хуулийн заалтууд:

- Аливаа мэдээллийг хэвлэн нийтлүүлэхээр, нэвтрүүлэхээр эсвэл хэвлүүлэхгүй гэж сэтгүүлчид хүч хэрэглэсэн, айлган сүрдүүлсэн хүнийг 3 жил хүртэлх хугацаагаар хорьж шийтгэнэ.
- Сэтгүүлч хууль зөрчсөн эсвэл өөрийнх нь үзэл баримтлалтай нийцээгүй ажлыг хийхгүй байх эрхтэй.
- Сэтгүүлчийн, хэвлэл мэдээллийн хэрэгслийн түгээсэн мэдээлэл нь бодит үнэнтэй нийцэхгүй ч редакц нийгмийн анхаарлыг тодорхой зүйлд хандуулах зайлшгүй шаардлага байсан гэж баталж чадвал сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хариуцлагаас чөлөөлнө. (Маш хурдан хугацаанд нийгэмд тодорхой мэдээлэл хүргэх зайлшгүй шаардлагатай, хоцорвол аюул учрахаар, нийгэмд хор хөнөөлтэй байж болзошгүй тохиолдолд мэдээллийг шуурхай хүргэх ёстой онцгой үүргийн хүрээнд хийсэн мэдээ, мэдээллийг энд хамааруулна).

³¹ Олон ургалч, чөлөөт хэвлэлийн тухай Европын Парламентын 2018 оны 5-р сарын 3-ны өдрийн тогтоол (2017/2209(INI))

³² <https://en.unesco.org/themes/safety-journalists/observatory>

³³ Олон ургалч, чөлөөт хэвлэлийн тухай Европын Парламентын 2018 оны 5-р сарын 3-ны өдрийн тогтоол (2017/2209(INI)) хуудас.7

Швейцарь Холбооны Улс

Швейцарын холбооны улсын хувьд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг тусгайлсан хууль болох “Телевиз, радиогийн тухай хууль”-иар зохицуулдаг. Тухайн хууль нь 6 бүлэг, 113 зүйлээс бүрдэх томоохон хууль бөгөөд сэтгүүлч түүний хараат бус, бие даасан байдлыг хуулийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйл буюу Хэвлэлийн байгууллагын үйл ажиллагааны зарчим хэсэгт хуульчилжээ. “Аливаа радио, телевизийн нэвтрүүлэг нь хүний суурь эрх чөлөөг хүндэтгэн, арьс өнгөөр ялгаварлан гадуурхалгүй, нийтийн ёс зүй, амар тайван байдалд нийцсэн байна” хэмээн хуульчилсан нь аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэвлэн нийтлэх эрхийн хүрээг тодорхойлж өгчээ. Харин тус хуулийн 6 дугаар зүйлд “сэтгүүлчийн хараат бус, бие даасан байдал”-ын талаар хуульчилсан бөгөөд Хуулийн 6.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол аливаа төрийн байгууллага нь сэтгүүлчид болон хэвлэлийн байгууллагын үйл ажиллагаанд оролцохгүй”, 6.2 дахь хэсэгт “Сэтгүүлч нь өөрийн программ, нэвтрүүлгийн утга, агуулгыг өөрөө сонгох эрхтэй бөгөөд дээрх мэдээлэлтэй холбоотой асуудлыг хариуцна” хэмээн хуульчилжээ.

Мөн хуулийн 12 дугаар зүйл 12.1 дэх хэсэгт “захиалгат нэвтрүүлгийн утга, агуулгатай холбоотой хариуцлагыг тухайн хэвлэлийн байгууллага хариуцах бөгөөд захиалагч болон санхүүжүүлэгч нь редакцын бие даасан байдалд нөлөөлөхүйц байдлаар оролцохгүй” гэжээ. Эндээс харахад сэтгүүлч нь өөрсдийн хариуцсан мэдээ, нийтлэлийн утгыг хэн нэгнээс хараат бусаар, бие даан шийдэх эрхтэй байхаар хуульчлан баталгаажуулжээ. Мөн үүний зэрэгцээ сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг санхүүжүүлэгчээс хамгаалсан байна.³⁴

Швейцарын холбооны улсын хувьд сэтгүүлчийн бие даасан, хараат бус байдлын талаар хуулиар зохицуулахаас гадна “Сэтгүүлчийн эрх ба үүргийн тунхаглал” гэх баримт бичгээр дэлгэрэнгүй зохицуулдаг байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Үндсэн хуулийнхаа тавдугаар зүйлд хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан байдаг ба үүнээс эх авсан Хэвлэл мэдээллийн тухай хууль нь 24 зүйлээс бүрдэнэ. Тус хуульд хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулахдаа “хэвлэл нь чөлөөтэй хэвлэн нийтлэх эрхтэй хэмээн нэн тэргүүнд тусгаснаас гадна үүнийгээ ардчилал эрх чөлөөний суурь мөн” хэмээн тайлбарлажээ. Харин тус улсын “Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм” нь 1993 онд Сэтгүүлчдийн холбооноос батлагдсан бөгөөд нийт 10 зүйлтэй. Дүрмийн 3 дугаар зүйлд “Сэтгүүлч нь мэдээллийн эрх чөлөө болон хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарласан үйлдэлтэй тэмцэж энэхүү үйлдлүүдийг нийгэмд мэдээлэх үүрэгтэй”. Дүрмийн 10 дугаар зүйлд “Сэтгүүлч нь өөрийн мэргэжлийн ёс зүй, хараат бус, бие даасан байдалд нөлөөлөхүйц хүсэлт, бэлэг хүлээн авахаас татгалзах үүрэгтэй. Сэтгүүлч нь өөрийн байр сууриа хувийн ашиг сонирхолдоо ашиглаж болохгүй” гэж тус тус зохицуулсан байна.

³⁴ М. Батсуурь . Эрх чөлөөг гагцхүү зүй ёсны хуулиар хязгаарлаж болно . “ Шихи - хутуг ” сэтгүүл . УБ ., 2006

Исланд Улс

Тус улсын хувьд 2000 оны тавдугаар сард батлагдсан “Радио, телевизийн тухай хууль” нь өөрийн улсад цацагдаж буй радио, телевизийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл, радио, телевизийн тусгай зөвшөөрөл олгох хороо, түүний эрх хэмжээ, зар сурталчилгаа, ивээн тэтгэгчийн эрх үүрэг, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг өргөн харилцааг зохицуулж байна³⁵. Тус хууль нь 12 бүлэг, 37 зүйлээс бүрдсэн бөгөөд сэтгүүлч, редакцын хараат бус, бие даасан байдлыг тусгайлан зохицуулсан зүйл байхгүй байна. Хуулийн 21 дүгээр зүйлд “радио, телевизийн байгууллага нь тусгайлан нэвтрүүлгийг ивээн тэтгэгчтэй явуулж болох бөгөөд ивээн тэтгэгч нь программ, нэвтрүүлгийн утга, агуулга, хэвлэлийн байгууллагын хариуцлага болон бие даасан байдалд нөлөөлөхгүй” гэсэн ганцхан зохицуулалт оржээ.

Норвеги Улс

Тус улс нь 1814 онд батлагдсан Үндсэн хуулийн 100 дугаар зүйлд “Хэвлэл мэдээлэл нь чөлөөтэй байна. Мэдээ, мэдээллийн утга нь хууль зөрчсөн, шашин, шүтлэг, нийгмийн ёс журмыг үл хүндэтгэсэн, аливаа этгээдийн нэр хүндэд халдсан, худал хуурмаг мэдээлэл цацсанаас бусад тохиолдолд хэвлүүлсэн болон хэвлүүлэхээр бэлтгэж буй этгээдэд хариуцлага ногдуулахыг хориглоно”³⁶ хэмээн анх удаа хэвлэлийн эрх чөлөөг хуульчилсан байна. Дээрх Үндсэн хуулиас гадна тусгайлан хэвлэл мэдээлэлтэй холбоотой харилцааг зохицуулахаар 1997 онд батлагдсан 11 бүлгээс бүрдэх “Радио, телевизийн тухай хуулиар” хэвлэл мэдээллийн харилцааг зохицуулдаг бөгөөд тус хуульд редакцын бие даасан, хараат бус байдлын тухай дурдсан зохицуулалт хараахан байхгүй байна.

Мөн тус улсын “Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм”-ийг 2007 оны 11 дүгээр сард “Норвегийн сэтгүүлчдийн холбооноос” баталсан бөгөөд Сэтгүүлч, редакцын хараат бус, бие даасан байдлын талаар дүрмийн 2.2 дахь хэсэгт “Сэтгүүлч, редакц нь өөрсдийн бие даасан, хараат бус ажиллах нөхцөл бололцоогоо аливаа гуравдагч этгээд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд нөлөөлөхийг хүсэж буй этгээдээс хамгаалах үүрэгтэй” гэжээ.

Швед Улс

Тус улс нь сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар” зохицуулдаг бөгөөд энэ нь 14 бүлэг, тус тусын зүйлээс бүрдсэн томоохон хууль юм³⁷. Тус хуульд сэтгүүлчийн мэдээлэл авах эрх болон хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг тусгайлан зааж, зөрчсөн тохиолдолд хэн, хэрхэн хариуцлага ногдуулах талаар тусгасан байна. Харин сэтгүүлч, редакцын хараат бус байдлын талаар зарим улстай харьцуулахад

³⁵ <https://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/is/is098en.pdf>

³⁶ <https://ihl-databases.icrc.org/ihl-nat/6fa4d35e5e3025394125673e00508143/eee956c813a2da0ec1256a870049de0c/%24FILE/Constitution.pdf>

³⁷ <http://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/44628/73451/F1101493786/SWE44628EnglishBasic.pdf>

анхаарал татах заалт цөөнгүй харагдсан юм. Үүнд хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Хэвлэлтээс өмнө ямар ч зүйлийг үл хянан шалгах ба ямар ч зүйлийн хэвлэлийг үл хориглоно” гэсэн зохицуулалтад хэвлэлийн байгууллагын бие даасан байдал, өөрсдийн эрх хэмжээний хүрээнд мэдээ, материалыг нийтлэх эрхийг хуульчилсан гэж үзэж болохоор байна.

Мөн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Цаашлаад ямар ч засаг захиргааны төв байгууллага болон аливаа төрийн байгууллагын зүгээс хэвлэгдсэн зүйлийг үндэслэн энэхүү хуульд зааснаас өөр хэлбэрээр арга хэмжээ авахыг хориглох ба тухайн материалыг хэвлэн нийтлэх, олон нийтэд тараахад саад болохыг хориглоно” гэж заасан нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээ, материалд үндэслэн тухайн хуульд зааснаас бусад тохиолдолд редакцын үйл ажиллагаанд төрийн байгууллагын зүгээс оролцохгүй, бие даасан хараат бус байдалд халдахгүй байхыг баталгаажуулжээ.

Мөн хуулийн 5 дугаар бүлгийн 3 дугаар зүйлд зааснаар “Тогтмол хэвлэлийн хариуцлагатай эрхлэгчийг хэвлэлийн эзэн томилно. Хариуцлагатай эрхлэгчийн үйл ажиллагааны хүрээнд тогтмол хэвлэлийн хэвлэлтийг хариуцан хангах, түүний хүслийн эсрэг ямар ч зүйл хэвлэгдэхгүй байхаар агуулгыг тогтоон тодорхойлох эрх багтана. Хариуцлагатай эрхлэгчийн эдгээр эрхийг хязгаарлах ямарваа хязгаарлалт нь хууль бус ба хүчингүй байна” гэж заажээ. Эндээс үзэхэд хариуцлагатай эрхлэгч буюу ерөнхий редакторын үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг тусгайлан хуульчилжээ.

Манайхтай ижил төстэй буюу пост коммунист улс орнуудын жишээг авч үзье:

Бүгд Найрамдах Польш Улс

2014 оны 9-р сарын 18-ны өдөр БНПУ-ын Үндсэн Хуулийн Цэцээс гаргасан тайлбарт “Хэвлэлийн тухай болон Радио телевизийн тухай хуулиудад - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан нэвтрүүлэг, мэдээ, мэдээллийн агуулга, түүнтэй холбоотой хариуцлагыг ерөнхий редактор үүрнэ. Мөн редакцын бодлого хийгээд санхүүжилтийн асуудал ерөнхий редакторын хариуцах ёстой ажил. Олон нийтийн болон хувийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрхлэн гаргагч нь редакцын өдөр тутмын ажил, бодлогод нөлөөлөхийг хориглосон”³⁸ гэж тусгажээ.

Тэгэхээр сэтгүүлчийн хэвлэн нийтэлсэн, нэвтрүүлсэн материал эздийн сонирхолд нийцэхгүй, хохирол учруулсан гэж үзсэн ч сэтгүүлчдэд нөлөөлөх боломжгүй гэсэн үг. Хэдийгээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд сэтгүүлчийн хувьд ажил олгогч хэдий ч ажилд авах, сонгон шалгаруулах зэрэг гол эрх мэдэл нь ерөнхий редакторт хадгалагдана. Ерөнхий редактор эрхлэн гаргагч, эздийн өмнө хариуцлага хүлээх ч редакцын ажлыг хараат бусаар зохион байгуулах, редакцын зөвлөлийг байгуулах, багаа бүрдүүлэх эрхтэй. Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан материалыг ерөнхий редактор дангаар хариуцах тухайг хуульчилж өгсөн байна.

³⁸ Польшийн Үндсэн Хуулийн Цэцийн цахим хаяг (<https://trybunal.gov.pl/>)

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн дотоод баримт бичигт ерөнхий редакторын ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлох ч үүгээр Радио телевизийн тухай болон Хэвлэлийн хуулиудын зүйл, заалтуудыг өөрчилж, гажуудуулж болохгүй. Үүнээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд, эрхлэн гаргагч, ерөнхий редактор болон сэтгүүлчдийн хоорондын харилцааг сэтгүүл зүйн өөрийн ёс зүйн дүрэмд журамласан байдаг.

Хэдий тийм ч Польшийн хууль тогтоомжид хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд, ерөнхий редактор, сэтгүүлчдийн хоорондын харилцаа, редакцын хараат бус байдлыг нарийвчлан баталгаажуулаагүй гэж шүүмжилдэг. Өөрөөр хэлбэл, эзэд, эрхлэн гаргагчидтай ижил түвшинд харилцаж чаддаг, сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалдаг холбоод, төрийн бус байгууллагуудын үүрэг оролцоо дутмаг байгаа юм.



Үймээн самууны үеийн сэтгүүл зүй ба сэтгүүлчийн аюулгүй байдал:

Үймээн самууны үеийн сэтгүүл зүй ба сэтгүүлчийн аюулгүй байдал:

Сэтгүүлчид аливаа жагсаал (зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй гэдгээс үл хамааран) цуглааныг үнэн бодитоор мэдээлэх үүрэгтэй. Төрийн байгууллагууд хөндлөнгөөс оролцохгүйгээр сэтгүүлчдэд уг үүргээ биелүүлэх боломжийг бүрдүүлэх ёстой. Жагсаал цуглаанд оролцогчид болон зохион байгуулагчдын зүгээс сэтгүүлчдэд ажил үүргээ чөлөөтэйгөөр гүйцэтгэхэд нь туслах, аюулгүй байдлыг нь хамгаалах үүрэгтэй.

Хэвлэл мэдээллийн салбарын төлөөлөгчид нь үйл явдлыг ажиглаж, дундыг баримталж оролцоно. Тийм ч учраас сэтгүүлч, фото сурвалжлагчийг сөргөлдөгч талууд гэж үзэх ёсгүй. Европын Хүний эрхийн байгууллагын тайлбарласнаар “Жагсаал цуглааныг мэдээлэх нь хэвлэл мэдээллийн салбарын үүрэг, ардчилсан тогтолцоог хамгаалах “хоточ нохойн” ажил” ажээ. Тэр ч утгаараа Хүний Эрхийн байгууллагын зүгээс хэвлэл мэдээллийн салбарын ажилчдын аюулгүй байдалд онцгой анхаарсан жишээнүүд олон байна.

Тухайлбал, 2020 оны зун болсон “Үр хөндөлтийн эсрэг хуулийг эсэргүүцсэн жагсаал, цуглааны үеэр Польшийн олон нийтийн телевиз TVP-ын зураглаачийг зодсон, өдөр тутмын сонины хоёр сурвалжлагч руу дайрсан хэрэгт сэтгүүлчдийг өмгөөлөн Польшийн Хүний эрхийн Төлөөлөгч Прокурорын газарт хандан, шаардлага хүргүүлж байв.

Бүгд Найрамдах Литви Улс

Иргэн бүр улсын болон орон нутгийн байгууллагаас мэдээлэл олж авах эрхтэй. Тэгвэл сэтгүүлчид дээрх байгууллагуудаас ажлын нэг өдрийн дотор мэдээлэл гаргаж өгөхийг шаардах эрхтэй. Хэрэв нэмэлт мэдээлэл шаардлагатай бол уг хугацаа долоо хоногоор сунаж болно. Харин мэдээлэл өгөхөөс татгалзсан байгууллага шалтгаанаа ажлын нэг өдрийн дотор бичгээр өгөх ёстой ажээ. Түүнчлэн, сэтгүүлчдэд мэдээлэл өгөөгүй, ажил үүргээ гүйцэтгэхэд нь хуулийн үндэслэлгүйгээр саад болсон төрийн албан хаагчид 20 - 140 еврогийн торгуул ногдуулдаг байна.³⁹

Сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхтэй ч онцгой тохиолдолд шүүхээс хуулийн хүрээнд сэтгүүлчийг мэдээллийн эх сурвалжаа ил болгохыг үүрэгдэж болно. Жишээ нь, сэтгүүлч Улсыг Аюулаас хамгаалах Албаны нууц мэдээллийг задруулсан тохиолдолд прокурор тухайн сэтгүүлчийн эсрэг мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, ажлын өрөө болон гэрт нь нэгжлэг хийх эрхтэй.

³⁹ Хуульчдад зориулсан эрх зүйн гарын авлага Liudvika Meškauskaitė, Dainius Sinkevičius (Lithuanian Journalism Centre)

Мөн мэдээллийн эх сурвалжийг олох зорилготойгоор хэвлэл мэдээллийн байгууллагын албан газар, сэтгүүлчдийн гэр, авто машинд үзлэг хийж болно. Чингэхдээ хуулийн хүрээнд тухайн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн өмчийн эзнийг байлцуулан хийнэ. Өөрөөр хэлбэл, тухайн сэтгүүлчийн ажил олгогч, түүнийг төлөөлөх эрх бүхий сэтгүүлчдийн эвлэлийн төлөөлөгч болон сэтгүүлчийн санал болгосон өөр хүнийг байлцуулахгүйгээр нэгжлэг хийхийг хориглодог ажээ.

Редактор, хэвлэл мэдээллийн байгууллагын эзний даалгасан үүрэг даалгавар нь хууль зөрчсөн болон мэргэжлийн ёс зүйн дүрмээс гажсан, сэтгүүлчийн өөрийн үзэл бодолтой харшилсан тохиолдолд сэтгүүлч уг ажлыг хийхээс татгалзах эрхтэй. Хэвлэл мэдээллийн байгууллага нь редакцын бодлого, ёс зүйн дүрэмдээ сэтгүүлчдийн эрхийг хязгаарлахаас сэргийлсэн зүйл заалтыг заавал оруулах үүрэгтэй. Гэсэн хэдий ч Литвад сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалах хүндрэлтэй хэвээр байна.

Литвын Үндсэн хуулийн 25-р зүйлд үг хэлэх эрхийг хязгаарласан 3 тохиолдлыг “1. Хүний хувийн амьдрал, нэр төр, нэр хүнд, эрүүл мэндийг хамгаалах зайлшгүй шаардлагын үүднээс, 2. Үндсэн Хуулийг хамгаалах үүднээс, 3. Арьс өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлахыг, олон нийтийг хүчирхийлэлд уриалахыг хориглох үүднээс” байхаар заажээ.⁴⁰

Бүгд Найрамдах Узбекистан Улс

Сэтгүүлчийн хараат бус байдлыг хууль гарган хамгаалсан сайн туршлагын тоонд Бүгд Найрамдах Узбекистан улсын жишээг дурдаж болно⁴¹. Тус улсын хууль тогтоох байгууллагаас сэтгүүлчийн хараат бус байдлыг тусгайлан бие даасан хууль батлах замаар шийдвэрлэсэн байна.

1997 онд батлагдсан Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах тухай хуулийн зорилго нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуульд Сэтгүүлчийн хараат бус байдлыг дараах байдлаар хуульчлан хамгаалсан байна. Үүнд: 1/ хуулийн 5 дугаар зүйлд “эрэн сурвалжлах сэтгүүл зүй эрхлэх”, “олон нийтийн мэдээллийн хэрэгслээс даалгасан ажил нь хууль зөрчсөн бол хийхээс татгалзах”, “бэлтгэсэн мэдээ мэдээлэл, материалаа өөрийн гарын үсэг, нууц нэрээр түгээх, түүгээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх”, “бэлтгэсэн мэдээ мэдээлэл, материалыг засварлахдаа агуулгыг нь гажуудуулсан гэж үзвэл түүнд гарын үсэг зурахгүй байх, түүнийг олон нийтэд хэвлэн нийтэлж нэвтрүүлэхгүй байхыг шаардах”, “сэтгүүлчийн бэлтгэсэн материалыг хэвлэн нийтлэхдээ агуулгыг нь гажуудуулж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэлсэнтэй холбоотойгоор түүнд учирсан сэтгэл санааны /ёс суртахууны

⁴⁰ Сэтгүүлчдэд зориулсан хууль зүйн гарын авлага Liudvika Meškauskaitė, Dainius Sinkevičius (Lithuanian Journalism Centre)

⁴¹ <https://lex.uz/acts/2024>

/болон эд хөрөнгийн хохирлыг /шүүхийн журмаар/нөхөн төлүүлэх/шаардах/ээр шүүхэд нэхэмжлэл гаргах” зэрэг эрхийг хуульчилсан.

2/ Сэтгүүлч мэргэжлийн үүргээ гүйцэтгэхдээ хувийн халдашгүй байдлын баталгааг эдэлнэ.

3/ Шүүмжтэй материал нийтэлснийх нь төлөө сэтгүүлчийг дарамтлах, мөрдөн шалгахыг зөвшөөрөхгүй зэргээр сэтгүүлчдийн эрхийг хамгаалсан байна.

Гүрж Улс

Гүрж улсын Радио, телевизийн тухай хууль 2004 онд батлагдсан бөгөөд 11 бүлэг, 77 зүйлээс бүрдэнэ⁴². Тус улсын Радио, телевизийн хуульд редакцын хараат бус байдлын тухай тодорхой зохицуулалтууд хийгджээ. Тухайлбал хуулийн 16 дугаар бүлэгт редакцын хараат бус болон нэвтрүүлгийн шударга, олон ургалч байдлыг баталгаажуулж, төр, улс төрийн хүчин, шашин болон арилжааны дарамт шахалтаас ангид байна”, 16.1-т “радио, телевизийн аливаа хараат бусаар бэлтгэсэн нэвтрүүлэг нь нэвтрүүлгийн цагийн 25%- иас доошгүй байна” хэмээн радио, телевизийн байгууллагуудын үүрэгт редакцын хараат бус байдлыг баталгаажуулжээ.

Мөн хуулийн 18 дугаар зүйлд Олон нийтийн радио, телевизийн хараат бус байдал ба дархлааны тухай зохицуулсан байна. Үүнд “Олон нийтийн радио, телевиз, түүний удирдлага болон ажилтнууд нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулж, гагцхүү хуульд захирагдана. Тэдний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж, оролцсон үйлдэл нь хариуцлагад татагдана” хэмээн заажээ. Дээрх улс орнуудын жишээнээс харахад манай оронд хэрэгжиж, хуульд хараахан тусгагдаагүй байгаа хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой дэвшилтэт зохицуулалтууд олон байна. Манай улсын хувьд олон нийтийн радио, телевизээс бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх редакцын хараат бус байдлыг баталгаажуулсан хууль байхгүй учир өмчлөгч болон редакц, сэтгүүлчийн хоорондын харилцаа хуулийн зохицуулалтгүй үлджээ.

Иймээс өмчлөгчөөс сэтгүүлчийн үйл ажиллагаанд хутгалдан орох, хяналт тавих, цензурдэх боломж нээлттэй бөгөөд ихэнх телевиз нь ямар нэгэн улс төрч, бизнесмений өмч, улмаар зөвхөн тухайн хүний үйл ажиллагааг сурталчилж, иргэдэд хэт нэг талыг барьсан, бодит бус мэдээллийг тараах явдал түгээмэл байна. Өөрөөр хэлбэл тухайн байгууллагад ажиллаж буй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан нь зөвхөн удирдлагаас зөвшөөрсөн, зааварчилсан мэдээллийг нийтэлж, ингэснээр өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагааг хараат бусаар явуулах боломж хязгаарлагдсан байна.

Санхүүгийн хомсдол нь сэтгүүлчдийг мэргэжлийн үйл ажиллагаанаас нь илүүтэй бизнес мэдээнд төвлөрүүлэх, эздийн эдийн засгийн болон улс төрийн сонирхол редакцын мэргэжлийн үйл ажиллагаанд хутгалдан орох үндэс болж байгааг үгүйсгэх аргагүй.

⁴² <https://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/ge/ge030en.pdf>

Хэвлэлийн эрх чөлөө харьцангуй хөгжсөн улсуудын эрх зүйн зохицуулалтыг аваад үзэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын эрх зүйн байдал, үйл ажиллагаа, тодорхой мэдээлэл нэвтрүүлэх журам болон улс төрийн болон эдийн засгийн хараат бус байдлыг хангах зохицуулалтын зэрэгцээ сэтгүүлчийн мэдээлэл хайж олох, эх сурвалжаа нууцлах зэрэг асуудлуудыг зохицуулсан боловч хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөгч, эздээс редакц хараат бус байх тухай редакцын хараат бус байдлын шууд тусгайлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй байна.

Цар тахлын үеийн сэтгүүл зүй:

Цар тахлын хүнд хэцүү үед болж буй нөхцөл байдлыг үнэн зөвөөр мэдээлэхийн төлөө амь насаа эрсдэлд оруулан ажилласан арван дөрвөн орны 17 сэтгүүлч 2020 оны Freedom of speech шагналын эзэд болцгоосон билээ.⁴³

НҮБ-ын Хүний эрхийн комиссар Мишел Бачелет Freedom of speech (Үг хэлэх эрх) шагналыг гардуулах ёслолын үеэр видеогоор дамжуулан үг хэлэхдээ “COVID-ын үед иргэдийг бодит, үнэн зөв мэдээллээр хангах, шийдвэр гаргахад туслах нь сэтгүүлчдийн үүрэг... Сэтгүүлчид цар тахлын нөхцөл байдлын тухай мэдээлснйхээ төлөө баривчлагдаж, ор сураггүй алга болж, аюул заналд өртөж байгаа нь харамсалтай” хэмээсэн юм.

2020 оны 12-р сарын байдлаар дэлхий дахинаа чөлөөт сэтгүүл зүйн эсрэг 482 хэрэг бүртгэгдсэнийг Олон Улсын Хэвлэлийн Институтээс зарласан байна.⁴⁴ Дэлхий нийтийг хамарсан гамшгийн энэ цаг үед өдөр тутмын үнэн бодит мэдээ, мэдээллийг олон өнцгөөс хүргэж чадаж буй, хараат бус сэтгүүлчидгүйгээр ардчилсан нийгмийг төсөөлөхийн аргагүй юм. Гэвч өнөөдөр дэлхийн гурван иргэний нэг үг хэлэх эрхгүй, хараат бус сэтгүүл зүй үгүй оронд амьдарч байгааг санах хэрэгтэй. Хэл хязгааргүй сурвалжлагчид байгууллага цахим хуудсаараа дамжуулан “Дэлхийн өнцөг булан бүрд дарангуйлагч дэглэмтэй улс орнууд, удирдагчид энэхүү аюултай өвчнийг далимдуулан үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хянах, хяналтыг нэмэгдүүлэх, улмаар төрийн цензурийг чангатгахыг оролдсоор байна”⁴⁵ хэмээн зарласан нь ч учиртай. Тиймээс бидэнд үг хэлэх эрх, эрх чөлөөгөө дээдэлж, чөлөөт, хараат бус сэтгүүл зүйг хөгжүүлэх, хамгаалах хүчин чармайлтаа бууруулахгүйгээр хэвлэл мэдээллийн салбарын хууль эрх зүйн орчноо улам төгөлдөржүүлэх шаардлага байсаар байна.

⁴³ “Үг хэлэх эрх чөлөө” шагнал, 2020 он. Deutsche Well/Freedom of speech award/2020

⁴⁴ Олон улсын Хэвлэлийн Институтийн цахим хаягт мэдээлсэн Ковид19-ын үед хэвлэлийн эрх чөлөөнд халдсан зөрчлүүд (<https://ipi.media/covid19/>)

⁴⁵ Олон улсын Хэл хязгааргүй сурвалжлагчид байгууллагын цахим хаяг (<https://rsf.org/en>)

ХОЁРДУГААР БҮЛЭГ

САЛБАР ХУУЛИУДАД СЭТГҮҮЛЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

2.1 Монгол Улс дахь сэтгүүл зүйн эрх зүйн орчин

Одоогоор Монгол Улсад нийт 770 гаруй хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хуулиудаас сэтгүүлчийн үйл ажиллагаатай шууд холбогдсон харилцааг зохицуулсан хэм хэмжээ гуч орчим хуульд тусгагдсан бол шууд бусаар 60 гаруй хуулиар уг харилцааг хуульчлан зохицуулсан байна.



Сэтгүүл зүйн салбартай шууд холбогдох хуулиуд нь Үндсэн хууль, Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Монгол Улсын Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Аж ахуйн, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль,

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай зэрэг хуулиуд байна.

Хэвлэл мэдээлэлтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомжийн эмхтгэлийг Глоб Интернэшнл төрийн бус байгууллагаас 2001 онд эмхэтгэн гаргасан бөгөөд дахин шинээр хэвлэгдээгүй байна.

Хэвлэл мэдээллийн салбарыг 2012 онд батлагдсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулиар стратегийн ач холбогдол бүхий салбарт хамааруулан хуульчилсан⁴⁶. Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг банк, санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарыг үндэсний аюулгүй байдалд стратегийн ач холбогдол бүхий салбар гэж тодорхойлсон байсан.

Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсантай холбогдуулан уг хууль хүчин төгөлдөр бус болсон⁴⁷. Гэвч Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар хуульчилсан нь өмнөх хуулийнхаа үзэл баримтлалыг уламжлан авсан зохицуулалт болсон. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн салбарыг үндэсний аюулгүй байдалтай холбоотойгоор стратегийн ач холбогдол бүхий салбарт тооцсон хуулийн зохицуулалт хэвээр байгаа юм.

Төрөөс хэвлэл мэдээллийн салбарт баримтлах бодлогыг тодорхойлсон баримт бичиг хараахан гараагүй байна. Харин Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалд дараах төрөөс хэвлэл мэдээллийн салбарт баримтлах бодлогыг тодорхойлсон зарим зүйлийг гуравдугаар зүйлд дараах байдлаар баталгаажуулсан байна⁴⁸. Үүнд:

1/Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана.

2/Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.

3/Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, **чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж**, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.

4/ Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ.

⁴⁶ “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль” - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2012 он №23 (740)

⁴⁷ “Хөрөнгө оруулалтын тухай хууль” - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2013 он №41 (806)

⁴⁸ “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2010 он №36 (657)

5/Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлаж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна. Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гаднын шашин, соёл, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хязгаарлана.

6/ Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана.

7/Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.2 Монгол Улсын Үндсэн хууль

Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотойгоор Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц болон Монгол Улсын Үндсэн хуулийг судлахдаа хэвлэн нийтлэх эрх чөлөө нь туйлын эрх чөлөө биш бөгөөд хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох эсхүл хувь хүний нууцыг задруулах зэргээр бусад хүний эрх, эрх чөлөөнд хохирол учруулсан үед өөртөө хариуцлага болон үүргийг бий болгодог гэдгийг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Үндсэн хуулийн хүрээнд хэвлэн нийтлэх эрх чөлөөг хамгаалах онолын асуудлыг түүний өнөөгийн практикийн хэрэгжилтийн хүрээнд судалж үзэхдээ Монгол Улсын Үндсэн хууль болон БНМАУ-ын Үндсэн хуулиудын хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбогдох зохицуулалт, тэдгээрийн үзэл баримтлалын талаар судлах шаардлагатай юм.

Энэхүү судалгааны суурь ойлголт болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь байгалиас заяасан шинж чанараараа хүний төрөлхийн мөн чанар, оршин буйн утга учир болдог тул аль улсын иргэн, харьяат байхаас үл хамааран заавал эдлэх эрх бөгөөд олон улсад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн нэг хэлбэр олон нийтэд мэдээллийг түгээх гол хэрэглүүр нь гэж үздэг ба энэ нь иргэний эдлэх эрхээс гадна сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд илүүтэй хамаардаг.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө бол хүний мөн чанар, оршин байгаатай нь холбогдон гарч ирдэг, төрөөс тогтоодоггүй, зөвхөн үндсэн хуулиараа баталгаажуулдаг, хүний төрөлх буюу оюун санааны эрх гэж ойлгож болно.⁴⁹

Бид 1990 оноос өмнө буюу социалист нийгмийн үед төр нь иргэдийг үг дуугүй захирч, өөртөө үйлчлүүлдэг нийгмийн үед амьдарч байсан бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл угтаа

⁴⁹ Б.Пүрэвсүрэн “Монгол Улс дахь хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт, тулгамдсан асуудал” (2019)



зөвхөн нэг намд үйлчилж байсан билээ. Энэ үед хүний үндсэн эрх болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө хэрэгжих ямар ч боломжгүй байсан бөгөөд 1992 оны ардчилсан Үндсэн хуулиас өмнө хэрэгжиж байсан 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх хэлбэрийн хувьд тунхаг төдий байснаас бус бодит байдал дээр эрхээ эдлэх боломжтой эрх чөлөөний түвшинд байгаагүй үзэж болно. Тэрхүү 70 орчим жилийн хугацаанд ард иргэдийн хүссэн, хэрэгцээтэй мэдээллийг бус зөвхөн засгийн эрх барьж буй хүмүүсийн түгээхийг хүссэн мэдээллийг л олон нийтэд ямарваа сонголтгүйгээр тулган хүргэж байлаа.

1980-аад оны сүүлээс өрнөсөн ардчилал өөрчлөлтийн үр дүнд пост социалист улс орнуудын хувьд хүний эрхийг тунхаглан хамгаалсан ардчилсан төр болохоо нотолж, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө итгэл хүлээх үндэс болгон хэвлэн нийтлэх эрхийг “Хүн бүр өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх ...”⁵⁰ (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) эрхтэй гэх зэргээр хуульчлан баталгаажуулсан нь уг эрх, эрх чөлөө нь хүн төрөлхтний нийтлэг ашиг сонирхолд үйлчлэх эрхэм зорилготой болохыг харуулж байгаа юм.

Хэвлэн нийтлэх эрх чөлөөний талаарх БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд дахь зохицуулалт

Хэвлэн нийтлэх эрх чөлөөг хамгаалах талаар Монгол Улсын өмнөх Үндсэн хуулиудад тодорхой хэмжээний зохицуулалт тусгагдаж байсан хэдий ч зөвхөн тунхгийн шинж чанартай байсан байна. Тухайлбал:

БНМАУ-ын 1924 оны Анхдугаар Үндсэн хууль

БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийг 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Анхдугаар Их Хурлын 14 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлээр баталж төр, иргэн хоёрын харилцааны үндсийг тодорхойлжээ.⁵¹

Энэ хуулийн гуравдугаар зүйлийн 7-д “Элдэв хэргийг жинхэнэ ард түмнээр шүүмжлэх эрхийг хүндэтгэж тус улсаас аливаа хэвлэх, нийтлэх явдлыг бүртгэн гүйцэтгүүлбэл зохино”⁵² хэмээн заасан нь үзэл бодлоо илэрхийлэх буюу шүүмжлэх эрхийг нээлттэй байлгаж, хэвлэл мэдээллийн хэрэгслийг бүртгэх явдлыг хуульчилсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг үндсэн хуульдаа тунхаглан заасан боловч хэвлэл мэдээллийн бүх хэрэгсэл эрх баригч намын хяналт, төрийн мэдэлд орсноос бүрэн хэрэгжээгүй гэж үзэж болох юм.

⁵⁰ Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992 он №1

⁵¹ “Монгол Улсын Үндсэн хууль 1924, 1940, 1960, 1992” нийтлэл. <https://www.parliament.mn/n/oapo> (2019.09.11)

⁵² Монгол Улсын Үндсэн хуулиуд. Хөх судар принтинг. УБ., 2007

БНМАУ-ын 1940 оны Үндсэн хууль

Анхны Үндсэн хууль нь сонгодог утгаар хүний эрх, эрх чөлөөг хуульчилж чадаагүй бол 1940 оны Үндсэн хуулиар тэгш эрхийн бүх нийтийн зарчмыг хэрэгжүүлж түүний энэ сул талыг нөхсөн байна. 1940 оны Үндсэн хуулийн ерэн наймдугаар зүйлд “Хөдөлмөрчдийн ашиг тусад тохируулан БНМАУ-ын төрийн байгууллыг бататган бэхжүүлэхийн тулд БНМАУ-ын ард иргэдэд хуулиар батлан олгох эрх нь:

- Чөлөөтэйгөөр үг хэлэх;
- Чөлөөтэй хэвлэн нийтлэх;
- Чөлөөтэйгөөр хурал цуглааныг хийх;
- Чөлөөтэйгөөр гудамжны жагсаал ёслол хийх болно гэж томьёолсон байна⁵³.

БНМАУ нь 1940 онд баталсан Үндсэн хуульдаа хэвлэл мэдээллийн цензурийн албан ёсны байгууллагын тухай зааж өгсөн бөгөөд Үндсэн хуулийн дөчдүгээр зүйлд “БНМАУ-ын Хэвлэл, утга зохиолыг хянах газар” нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд шууд харьяанд ажиллах тухай заажээ⁵⁴.

БНМАУ-ын 1960 оны Үндсэн хууль

Гурав дахь Үндсэн хуулийн ард иргэний үндсэн эрх, үүргүүдийн тухай долоодугаар бүлгийн 87 дугаар зүйлд “БНМАУ-ын төрийн байгууллыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор Хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэн БНМАУ-ын иргэдэд:

1. Үг хэлэх
2. Хэвлэн нийтлэх
3. Хурал цуглаан хийх
4. Жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг хуулиар батлан олгосон байна.

Эдгээр эрх чөлөөг эдлэхэд бодит улс төр, үзэл суртал, хууль зүйн орчин хангалтгүй байсан болно. Доктор Б.Чимид агсаны хэлснээр, 1990-ээд он хүртэл намын дайчин зэвсэг гэгдэн, нэгэн үзэл суртлын ноёрхлоос гарч чадаагүй юм.⁵⁵ Өмнөх хоёр Үндсэн хуультай харьцуулахад үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний баталгааг хуульчлахдаа илүү товч, тодорхой томьёолон оруулсан байна.

Өмнөх Үндсэн хуулиудад үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний талаар тусгасан хэдий ч уг асуудлын талаарх олон улсын харилцааны нийтлэг үүргийг хүндэтгэн хандаагүй, ардчиллын гол зарчмууд тусгагдаагүй, тусгагдсан зарим нь хязгаарлагдсан, улмаар нэг үзэл сурталд

⁵³ “Монгол Улсын үндсэн хуулиуд”. Хөх судар принтинг. УБ., 2007

⁵⁴ Д.Оросоо “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, түүнийг хэрэгжүүлэх арга, хэлбэр” сэдэвт магистрын дипломын ажил. (УБ., 2002 он).

⁵⁵ Б.Чимид. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө. “Үндсэн хуулийн үзэл баримтлал”, (УБ 2002 он).

хатуу захирагдаж байсан зэрэг нь дотоодын болоод гадаадын нөлөөтэй байсан учраас ихэнх заалт нь биеллээ олоогүй тунхаглал болон үлдсэн байна.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль

Ардчиллын оршин тогтнох баталгаа нь ил тод байдал, олон ургалч үзлийн индэр болсон чөлөөт хэвлэл, хэвлэл мэдээллийн эрх чөлөө байдаг.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө...”-г баталгаатай эдлэхээр зохицуулжээ⁵⁶. Эдгээр эрх, эрх чөлөө нь хоорондоо нягт холбоотой, нэгийг нь хязгаарлахад нөгөө нь хөндөгдөж байдаг учир ийнхүү нэг зүйлд багтаан баталгаажуулсан байна⁵⁷. Мөн тус зүйлийн 17 дахь хэсэгт хүн бүр “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх”-тэй болохыг заасан.

Мэдээлэл хайх, хүлээн авах нь хэвлэн нийтлэх замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдлэх боломжийг бүрдүүлж, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагууд хүссэн мэдээллээ хайх, хүлээн авсны үр дүнд эцсийн зорилго болох түгээснээр илэрхийлэх баталгаа болдог.

Эдгээр эрх, эрх чөлөө нь хоорондоо нягт уялдаа холбоотой, нэгийг нь хязгаарлахад нөгөө нь хөндөгдөж байдаг тул нэг зүйлд багтаан баталгаажуулжээ. Мэдээлэл хайх, хүлээн авах эрх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдлэх боломжийг бүрдүүлж иргэд, хэвлэл, мэдээллийн байгууллагууд хүссэн мэдээллээ хайх, хүлээн авах, илэрхийлэх баталгаа болсон байна.

Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар (16.16) итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Мөн зүйлийн 17-д зааснаар төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хуульчлан баталгаажуулсан нь манай улсын Үндсэн хуулийн эрх зүйн түүхэнд томоохон ололт болсон юм.

Энэхүү Үндсэн хуульд заасан үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх нь нийгмийн ач холбогдолтой асуудлаар өөрийн үзэл бодлоо ил тод, чөлөөтэй илэрхийлэх, мэдээллийг бүхий л эх сурвалжаас хууль ёсны аргаар олж авах эрхийн нийлбэр юм.

Харин мэдээллийг “түгээх эрх”-ийн хувьд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй...” гэж хэвлэн нийтлэх эрхийн шинжүүдийг баталгаажуулжээ. Ингэхдээ “түгээх эрх”-ийг үгчлэн заалгүйгээр орхигдуулсан байна. Гэвч агуулгын

⁵⁶ Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992 он №1

⁵⁷ Д.Гангабаатар “Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн хуулиар хамгаалах нь”, (УБ., 2015), 3 дахь тал

хувьд өөр нэг үндэслэл бол “...мэдээллийг хайх, хүлээн авах гэдэг нь уг эрхийг хэрэгжүүлэх эцсийн зорилго биш. Харин тодорхой зорилгод хүрэхийн тулд эдлэх эрх юм. Иймд энэ эрхийн мөн чанар, зорилгыг агуулсан мэдээллийг нийтийн болгон тараах эрх гэдэг нь Үндсэн хуулийн энэхүү хэм хэмжээний логик юм.

Мөн дээрхээс үзвэл, “мэдээлэл түгээх” гэсэн томъёолол орхигдсон боловч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь нэг талдаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, түгээх эрх чөлөө, нөгөө талаас илэрхийлсэн үзэл бодлыг хүлээж авах эрх чөлөөгөөр зэрэг нөхцөлдсөн байдгийн хувьд нэг нь нөгөөгүйгээр орших боломжгүй” гэж 2000 оны “Үндсэн хуулийн тайлбар” (Г.Совд) -т дурдсан байна.⁵⁸

Сүүлийн үед мэдээллийг эрж хайх, олж авах, хүлээн авах, түгээх нь харилцан адилгүй ойлголт болжээ. Учир нь эрж хайх, олж авах үйлдэл хийх нь хувь хүнээс идэвх, оролцоо шаардаж байдаг бол хүлээн авах нь гэртээ зурагтынхаа өмнө, замын хөдөлгөөнд оролцох, радио сонсож байхдаа гэх зэргээр идэвх шаардахгүйгээр хүн мэдээлэл хүртэж болдгоороо ялгагддаг. Харин түгээх эрхийн тухайд мэдээлэл эрж хайж, олж авлаа ч түгээх зорилго агуулаагүй байж болдгоороо онцлог байна.

⁵⁸ Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан нар “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” (УБ.,2000 он) 124 дэх тал

2.3 Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын Хүний эрхийн тухай гэрээ конвенцод хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний талаар туссан байдал

“Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хэвлэн нийтлэх эрх чөлөөгөөр дамжин хэрэгжих нь түүний хамгийн том арга, хэлбэр юм.”

Дэлхий нийт болон бүс нутгийг хамарсан дайн дажин, зарим улс оронд тогтсон дарангуйллын улмаас хүний эрх ихээр зөрчигдөж, түүнтэй тэмцэх нь олон улсын асуудал болж энэхүү шаардлагаар НҮБ байгуулагдсан нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг батлан гаргах урьдчилсан нөхцөл болсон юм⁵⁹. ХЭТТ-ийг 1948 оны 12 дугаар сарын 10-нд Нэгдсэн Үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан нь хүний эрх, эрх чөлөөг тунхагласан түүхэн үйл явдал байлаа.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн анхдугаар чуулга уулзалтын 59-р тогтоолоор (1948) “Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд...НҮБ-аас тунхагласан бусад эрх, эрх чөлөөг хэмжих үндсэн хэмжүүр мөн” гэж үзсэн бол энэхүү мэдээллийн эрх чөлөөний бүрэлдэхүүн хэсэг болох хэвлэн нийтлэх эрх чөлөө нь хувийн ба улс төрийн шинжтэй харилцаанд хүний эдлэх эрхийн нэг юм.

Энэ эрх нь НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А тогтоолоор ИБУТЭОУП-аар баталгаажсан эрх тул улс төрийн эрх чөлөөнд хамаарна⁶⁰.

Энэхүү улс төрийн эрх, эрх чөлөөний эх сурвалж, анхдагч суурь эрх бол үзэл бодлын эрх, эрх чөлөө юм. ИБУТЭОУП-д хөндлөнгийн оролцоогүйгээр үзэл бодлоо баримтлах эрхийг хамгаалсан. Энэ нь хязгаарлалтгүй, саадгүйгээр Засгийн газрын хүлээн зөвшөөрөх ёстой эрх мөн.

Монгол Улс НҮБ-д 1961 онд гишүүнээр элсэн орсон бөгөөд гишүүн орны хувьд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг соёрхон баталж, 2012 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэн. Тиймээс олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй.

Энэ үүргийг Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”⁶¹ гэж заасан.

⁵⁹ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал - “Төрийн мэдээлэл” тусгай дугаарын I боть (2004 он)

⁶⁰ ИБУТЭОУП - “Төрийн мэдээлэл” тусгай дугаарын I боть (2004 он)

⁶¹ Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992 он №1

Монгол Улсын хувьд, үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой хүний эрхийн олон улсын нийт 17 гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд нэгдэн орж, зохих үүрэг хүлээсэн байна.

- **Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал**

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэхүү эрхэд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж заажээ.

- **Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пакт: (ИБУТЭОУП)**

Монгол Улс 1974 онд ИБУТЭОУП-ыг соёрхон баталсан бөгөөд энэхүү пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрхтэй” гэж заасан⁶².

Монгол Улс ИБУТЭОУП-ыг соёрхон баталснаар үзэл бодолтой байх, үзэл бодлоо баримтлах, өөрчлөх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эсвэл илэрхийлэхгүй байх эрх чөлөөг бүхэлд нь хүлээн зөвшөөрч, олон улсын хэм хэмжээг даган мөрдөх учиртай. ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлд НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 102 дугаар чуулганаар 34 тоот ерөнхий тайлбарыг баталсан. Энэ ерөнхий тайлбарт “үзэл бодолтой байх эрх” нь “хүний өв тэгш хөгжлийн зайлшгүй нөхцөл бөгөөд эдгээр нь аль ч нийгмийн язгуур мөн чанар, аливаа чөлөөт, ардчилсан нийгмийн тулгын чулуу мөн” гэж заасан⁶³.

Түүнчлэн өөрийн угийн, ухамсарласан, эсвэл таамагласан үзэл бодлын улмаас ямар ч хүн Пактаар хамгаалагдсан аливаа эрхээ эдлэхдээ хохирох ёсгүй. Үүнээс гадна улс төр, шинжлэх ухаан, түүх, зан суртахуун, шашны мөн чанараас улбаалсан үзэл бодлыг хамруулан үзэл бодлын бүхий л эрх чөлөөг Пактаар хамгаалсан. Үүнтэй холбоотойгоор үзэл бодолтой байхыг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх нь Пактын заалттай харшилна гэж тайлбарласан.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй”⁶⁴ гэсэн заалт нь энэ эрхийг хамгаалж буй зохицуулалт болно. Үзэл бодлын шалтгаанаар баривчлах, саатуулах, шүүх, шоронд хорихыг хамруулан дарамт үзүүлэх, айлган сүрдүүлэх, нэр хоч өгөх нь Пактын 19

⁶² ИБУТЭОУП-ын 19.3 заалт - “Төрийн мэдээлэл” тусгай дугаарын I боть (2004 он)

⁶³ ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 34 тоот ерөнхий тайлбар

⁶⁴ Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга) – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2016 он №07 (916)

дүгээр зүйлийг зөрчсөнд тооцогдоно. Үзэл бодолтой байх, үзэл бодолгүй байхыг албадах аливаа хэлбэрийн оролдлого хийхийг хориглоно. Мөн Үзэл бодолтой байх эрх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө нь үзэл бодлоо илэрхийлэхгүй байх эрх чөлөөг зайлшгүй агуулж байдаг.

Дээр дурдсан олон улсын хэм хэмжээ тогтоосон баримт бичгүүдэд:

- **Сэтгүүлчийн талаар:**

ЮНЕСКО-гийн Мэдээлэл харилцааны хөгжлийн олон улсын хөтөлбөр (МХХОУХ)-ийн 2012 оны 3-р сарын 23-ны шийдвэрт “Олон нийтийн эрх ашиг бүхий сэтгүүл зүйн үйл ажиллагаанд татагдан оролцдог сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, нийгмийн сүлжээний туурвигчид” гэж томъёолсон.

2014 оны 11 дүгээр сард МХХОУХ-ийн Засгийн газар хоорондын Зөвлөлийн 29-р чуулганаар “Сэтгүүл зүйн үйл ажиллагаанд татагдан оролцдог сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, нийгмийн сүлжээний агуулга туурвигчид” хэмээн өөрчлөн тодорхойлжээ. Энэ утгаар сэтгүүлчдэд сурвалжлагч, гэрэл зургийн сурвалжлагч, агуулга туурвихад дэмжлэг үзүүлдэг ажилтан, хүйн хэвлэл мэдээллийн идэвхтэн, иргэний сэтгүүлчид багтана. Өөрөөр хэлбэл, нийгмийн сүлжээ, цахим хэвлэл мэдээллийн бүх хэрэглэгч бус олон нийтийн эрх ашиг бүхий агуулгын үлэмж хэсгийг туурвигч, эрхлэгч, түгээн дэлгэрүүлэгчид багтана⁶⁵.

- **Гишүүнчлэл:**

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны Үндсэн хуулийн “Гишүүнчлэл” хэмээх бүлгийн 4.а зүйлд “Сэтгүүлч гэж ажлын цагийнхаа дийлэнхийг сэтгүүлзүйн мэргэжлийн үйл ажиллагаанд зориулдаг, орон тооны, эсвэл чөлөөт байдлаар орлогынхоо ихэнхийг энэ ажлаас олдог хүнийг хэлнэ”.

Энэ бүлгийн 5-р зүйлд “Ердийн гишүүнчлэлийн хувьд ажил олгогчдыг хамруулдаг сэтгүүлчийн эвлэл холбоо, эсвэл мэргэжлийн бусад тусгай салбарт үйл ажиллагаа явуулдаг эвлэл холбоонд ОУСХ-ны гишүүнчлэл нээлттэй бус”⁶⁶ гэсэн байдаг.

Сэтгүүлчдийг мэргэжлийн эвлэл холбооны гишүүн байхыг хүчээр тулгах нь эмзэг асуудал юм. Практик дээр сэтгүүлчид сайн дураараа ийм байгууллагад идэвхтэйгээр нэгдэх, эсвэл өөрсдөө дундаа шинэ бүлэг хэсэг байгуулдаг. Холбоо, үйлдвэрчний эвлэл байгуулах нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, ИБУТЭОУП-ын 22-р зүйлээр баталгаажуулсан тусдаа хүний эрх юм.

⁶⁵ Глоб Интернэшнл ТББ-ын 2019 оны 10 сарын 18-ны өдрийн нийтлэл <https://www.gic.mn/post/r/1475>

⁶⁶ Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны Үндсэн хууль - <https://www.ifj.org/who/rules-and-policy/constitution.html>

Сэтгүүлчдийн эвлэл холбоо нь хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулахад тустай, мөн сургалт хийх, гишүүддээ үйлчилдэг ёс зүйн зарчим батлах замаар гишүүдийнхээ мэргэжлийн ба ёс зүйн хэм хэмжээг нэмэгдүүлэхэд туслах зорилготой байгууллага юм.

- **Хязгаарлалтын талаар:**

Олон улсын хэм хэмжээнд хэвлэн нийтлэх эрх чөлөө нь туйлын эрх чөлөө биш тул тодорхой, нөхцөл, болзлыг хангасан тохиолдолд түүнийг хязгаарлахыг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх гол арга замын нэг хэвлэн нийтлэх эрх чөлөөг зөвхөн хуулийн хүрээнд бөгөөд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх, нэр төрийг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хязгаарлаж болно.

Харин энэ эрхээ эдлэхдээ бусдыг гүтгэсэн, доромжилсон, худал мэдээлэл тараасан этгээд хуульд заасан хариуцлага хүлээх ёстой ба энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2-т “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг эрх зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана”⁶⁷.

ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3-т “...түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой”⁶⁸ гэжээ. Үүнд:

- а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
- б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.

Хязгаарлалтыг оногдуулахдаа хуулиар хийх, хэмжээг оногдуулах, зайлшгүй шаардлагатайг нотолсон байх гэсэн гурван шаардлагыг нэгэн зэрэг хангасан байх ёстой байна.

⁶⁷ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал - “Төрийн мэдээлэл” тусгай дугаарын I боть (2004 он)

⁶⁸ ИБУТЭОУП - “Төрийн мэдээлэл” тусгай дугаарын I боть (2004 он)

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжуудад тусгасан байдал

3.1 МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ⁶⁹

<p>Хуулийн зорилт</p>	<p>Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, -эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.</p>
<p>Холбогдох зүйл заалт</p>	<p>Арван зургаадугаар зүйл. Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно; 17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;</p>
<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан байна. Энэ нь Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөг Үндсэн хуулийн хүрээнд хамгаалсан хуулийн зохицуулалт юм.</p> <p>Мэдээллийн эрх чөлөөг “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан нь Үндсэн хуулийн хүрээнд баталгаажуулжээ.</p> <p>Үндсэн хуулийн дээрх заалтуудыг үндэслэн органик хуулиуд болон бусад салбар хуулиудад хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах чиглэлээр хуульчлан баталгаажуулах ёстой. Энэ хүрээнд Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээг тусгасан биеэ даасан хууль батлан гаргах эрх зүйн үндэслэл бүрдэж байна.</p>

⁶⁹ Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992 он №1

3.2 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ⁷⁰

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.
Холбогдох зүйл заалт	<p>1/2 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.</p> <p>2/3 дугаар зүйл. Мэдээлэлд хяналт тавихыг хориглох</p> <p>3.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.</p> <p>3/3.2. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.</p> <p>4/4 дүгээр зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.</p>
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах харилцааг зохицуулсан хэм хэмжээ:	<p>Уг хууль нь хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлыг дэмжих, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль төрөөс батлан гаргах, төрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглох, түүнчлэн олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тавихгүй байх асуудлыг хуульчилж, чөлөөт хэвлэлийн эрх зүйн суурь харилцааг зохицуулах алхам хийснээрээ ач холбогдолтой.</p> <p>Гэвч уг хууль батлагдан гарснаас хойш Монгол Улсад хэвлэл мэдээллийн тоо, цар хүрээ, нэр төрөл хурдтай нэмэгдэж, хууль эрх зүйн нарийн зохицуулалт шаардах болсон. Үүний зэрэгцээ Монгол Улсад хэвлэл мэдээллийн хараат бус байдал алдагдаж, чөлөөт хэвлэл, мэргэжлийн сэтгүүл зүйн орон зай хумигдах эрсдэл нэмэгдэж байна.</p>

⁷⁰ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1998 он №10 (77)

<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Сэтгүүл зүйн хараат бус байдал алдагдаж байгаа нь иргэдийн мэдээлэл авах эрх, эрх чөлөө хумигдах, нийгэмд ёс суртахууны доройтол, хямрал, тогтворгүй байдал үүсэж гүнзгийрэх зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгож байна. Ийм нөхцөлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гомдол, маргааныг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт хомс, сэтгүүл зүйн салбарт өөрийн зохицуулалтын механизм байхгүй байгаа нь байдлыг хүндрүүлж байна.</p> <p>Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хууль нь зөвхөн төр, хэвлэл мэдээллийн харилцааг зохицуулсан хязгаарлагдмал агуулгатай бөгөөд хэвлэл мэдээллийн салбарт тулгамдаж байгаа Сэтгүүлчийн хараат бус байх асуудал үндсэндээ эрх зүйн тодорхой зохицуулалтгүй байна.</p>
---	--

3.3 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ⁷¹

<p>Хуулийн зорилт</p>	<p>Энэ хуулийн зорилт нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>
<p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Уг хуулийн 5 дугаар зүйлд мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг хуульчилсан.Тухайлбал, хууль дээдлэх, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх, хараат бус байх, мэдээллээр хангах үйл ажиллагаа шуурхай байх.</p> <p>Хуульд мэдээллийн ил тод байдал, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал, төсөв, санхүүгийн ил тод байдал, иргэд, байгууллага мэдээлэл чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан.</p>
<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Энэ хууль нь ач холбогдлын хувьд төрөөс сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр батлан гаргасан үндсэн хэм хэмжээ болсон юм.</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 оны 6 дугаар сард баталсан боловч уг хуульд нийцүүлж бусад хуульдаа өөрчлөлт хийгээгүй. Уг хуулийн 2.1-р зүйлд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Хувь хүний нууцын тухай энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан. Өөрөөр хэлбэл одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Нууцын тухай багц хууль нь Мэдээллийн ил тод байдал,</p>

⁷¹ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2011 №26 (695)

	мэдээлэл авах эрхийн тухай хуулийн салшгүй нэг хэсгийн хувьд уг хуулийн үйлчлэх хүрээг хязгаарлах хүчин зүйл нь болсоор байна.
--	--

3.4 ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ⁷²

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь Монголын ард түмэнд үйлчлэх олон нийтийн радио, телевизийг үүсгэн байгуулж, түүний зорилго, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоож, хөтөлбөрийн бодлогын үндсийг тодорхойлоход оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуулийн 3 дугаар зүйлд “Олон нийтийн радио, телевиз нь олон нийтийн радио, телевиз энэ хуулийн дагуу байгуулагдаж, гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн. Олон нийтийн радио, телевизийн зорилго нь үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход оршино “гэж заасан.</p> <p>Хуульд олон нийтийн радио, телевиз, түүний зорилгыг “олон нийтийн радио, телевиз нь гадаадын сонсогч, үзэгчдэд зориулсан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, Монгол Улсын гадаад, дотоод бодлогын талаар мэдээлэх, Монгол орныг дэлхий дахинд сурталчлах, таниулах чиглэлийн хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэж түгээх” гэж тодорхойлжээ.</p> <p>Хуулийн 4 дүгээр зүйлд олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны үндсэн зарчим хуульчилсан. Уг зүйлийн 4.1 дэх хэсэгт “Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх, олон ургалч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална” гэжээ.</p> <p>Уг хуулийн 5 дугаар зүйлд олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакцын хараат бус байдлыг хангах үндсийг хуульчилсан.</p> <p>Уг зүйлийн 5.1 дэх хэсэгт “Олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакц Үндсэн хууль болон энэ хуулийн үзэл санаанд нийцсэн нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, олон нийтийн радио, телевизийн удирдлага хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно” гэжээ.</p>

⁷² Олон нийтийн радио телевизийн тухай хууль, 4,21,31 дүгээр зүйл- “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2005 №8 (389)

	<p>Уг хуулийн 17 дугаар зүйлд олон нийтийн радио, телевизийн санхүүжилтийн эх үүсвэрийг дараах байдлаар хуульчилжээ:</p> <p>17.1.1.радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс; 17.1.2.зар сурталчилгаанаас олсон орлого; 17.1.3.тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого; 17.1.4.Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнээс өгсөн хандив, тусламж; 17.1.5.улсын төсвийн дэмжлэг; 17.1.6.хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.</p> <p>Хуулийн 21 дүгээр зүйлд Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох зохицуулалтыг дараах байдлаар хуульчилжээ.</p> <p>21.1.Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх орон тооны бус байгууллага бөгөөд 15 гишүүнтэй байна.</p> <p>21.2.Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна.</p> <p>21.3.Үндэсний зөвлөлийн гишүүнд дараах этгээдийг нэр дэвшүүлэхгүй:</p> <p>21.3.1.төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч; 21.3.2.улс төрийн намын удирдах албан тушаалтан; 21.3.3.бусад радио, телевизэд ажиллаж байгаа, түүнчлэн ажилладаггүй боловч хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход нь оролцдог этгээд; 21.3.4.бусад радио, телевизэд хөрөнгө оруулалт хийсэн этгээд, эсхүл олон нийтийн радио, телевизийн санхүүгийн хараат бус байдалд нөлөөлж болох этгээд.</p> <p>21.4.Үндэсний зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосон Монгол Улсын иргэнийг томилно.</p> <p>21.5.Энэ хуулийн 21.3, 21.4-т заасан шалгуурыг удирдлага болгон дор дурдсан байгууллага, албан тушаалтан Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ:</p> <p>21.5.1.Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн; 21.5.2.Монгол Улсын Их Хурал 7 хүн; 21.5.3.Монгол Улсын Засгийн газар 4 хүн.</p> <p>Дээрх зохицуулалт нь улс төрчдөөс хараат бус байдалд үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байгаа юм.</p> <p>21.6.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид; эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн</p>
--	---

	<p>чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд; эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.</p> <p>21.8.Энэ хуулийн 21.7-д заасны дагуу нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно” гэжээ.</p>
<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Уг хуулийн 34 дүгээр зүйл. Мэдээлэл олж авах, мэдээллийн эх сурвалжийг нууцлах талаар хуульчилсан. Уг зүйлийн 1 дэх хэсэгт “Олон нийтийн радио, телевизийн ажилтан төр, байгууллага болон хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг олж авах, нийтийн хүртээл болгох эрхтэй” гэж заасан. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт 34.2 “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан нь Сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.</p> <p>Гэвч энэхүү эрх зүйг зохицуулалт нь зөвхөн Олон нийтийн радио, телевизийн ажилтанд л хамаардаг. Учир нь уг хуулиар зохицуулах харилцаа нь олон нийтийн радио, телевизийг үүсгэн байгуулж, түүний зорилго, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоохтой холбоотой.</p> <p>Энэ нь хэдийгээр мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхийг олгосон цорын ганц эрх зүйн зохицуулалт боловч нийт сэтгүүлчдэд хамаарахгүй байгаа нь сэтгүүлчийг ажиллаж буй салбараар нь ялгаварлан хуульчилсан хэлбэрийн илрэл болж байна гэж үзэх үндэслэлтэй байна. Иймд сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхийг нийт сэтгүүлчдэд олгох чиглэлээр хууль батлан гаргах нь төрийн үүрэг гэж үзэж байна.</p> <p>Үүний зэрэгцээгээр уг хууль нь Олон нийтийн радио, телевизийн сэтгүүлчдийн хууль ёсны эрх ашиг, хараат бус байдлыг хангаж чадахгүй байгаа талаарх шүүмжлэлийг УИХ-ын хуралдаан дээр зарим гишүүд илэрхийлж уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой гэж үзжээ.</p> <p>Мөн Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн уран бүтээлчид энэ оны аравдугаар сарын 21-ны өдөр үндэсний зөвлөлийнхөө гишүүдийг огцрохыг шаардан мэдээлэл хийсэн. Энэ хурлаар МҮОНРТ-ийн Захирлуудын зөвлөлийг огцруулахыг шаардаж, 250 гаруй уран бүтээлчид гарын үсгээ зурсан гэдгээ мэдэгдэж, холбогдох баримтуудыг дэлгээд буй. Тус телевизийн уран бүтээлч, сэтгүүлчид МҮОНРТ-ийн редакц хараат болсон бөгөөд</p>

	иргэдийн мэдэх эрхэд халдаж байна гэж үзэж байгаагаа ярьсан юм ⁷³ . Үүнээс үзвэл Сэтгүүлчийн хараат бус байдлыг хуульчлахдаа улс төр эдийн засгийн хараат бус байдлыг хангахгүйгээр хуульчилбал сөрөг үр дагаварт хүрч болохыг харуулж байна.
--	--

3.5 ЭРҮҮГИЙН ХУУЛЬ⁷⁴

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуулийн 13.14 дүгээр зүйлд худал мэдээлэл тараахыг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Уг зүйлд хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заасан.</p> <p>Мөн хуулийн 14.8 дугаар зүйлд сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэргийг хуульчилсан. Уг зүйлд сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заасан.</p> <p>Хуулийн 19.12 дугаар зүйлд төрийн маш нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан.</p> <p>Хуулийн 19.12 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн, прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олон нийтэд задруулсан бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан.</p>

⁷³ <https://news.mn/r/2364719/>

⁷⁴ Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга) – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2016 он №07 (916)

	<p>Мөн хуулийн 13.10 дугаар зүйлд хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан.</p> <p>Хуулийн 13.12 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгөсөн бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ. Иймд эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хуульчлах үүднээс Эрүүгийн хуулийн энэ зүйлд зохих өөрчлөлт оруулах нь зүйтэй.</p>
<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Хуулийн 4.3 дугаар зүйлд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах гэмт хэргийг хуульчилсан. Уг зүйлд зааснаар “ Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэжээ.</p> <p>Энэ зохицуулалтыг сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалсан хэм хэмжээнд хамааруулан авч үзэж болно.</p> <p>Эрүүгийн хуульд худал мэдээлэл тараахыг гэмт хэрэгт тооцохоор 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хуульчилсан байна. Энэ нь хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах хууль тогтоомж гаргахыг хориглосон боловч дээрх зохицуулалт нь хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.</p> <p>Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хуульчлах үүднээс Эрүүгийн хуульд зохих өөрчлөлт оруулах нь зүйтэй.</p>

3.6 ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ⁷⁵

<p>Хуулийн зорилт</p>	<p>Энэ хуулийн зорилт нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.</p>
<p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Уг хуульд худал мэдээлэл тараахыг зөрчлийн хэрэгт тооцохоор хуульчилж байсныг Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцохоор 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хуульчилсан нь Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах хууль тогтоомж гаргахыг хориглосон заалттай зөрчилдөх нөхцөлийг бүрдүүлж байна.</p> <p>Мөн түүнчлэн хуулийн 5.13 дугаар зүйлд гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан.</p> <p>Уг хуулийн 5.10 дугаар зүйлд терроризмтой холбоотой мэдээ, мэдээллийг төрийн холбогдох байгууллагад даруй өгөх, эсхүл террорист үйлдэл, үйл ажиллагаанд өдөөн хатгасан аливаа явуулга, суртал ухуулга, үзэл санаанд автахгүй байх, терроризмыг сурталчлах, олон нийтэд уриалах, нийтийн өмнө зөвтгөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх заалтыг зөрчвөл торгох шийтгэл оногдуулахаар заажээ.</p> <p>Уг хуулийн 5.18 дугаар зүйлд онц байдал тогтоосон шийдвэр, онц байдлын үеийн онцгой арга хэмжээ, нэмэлт онцгой арга хэмжээ, онцгой арга хэмжээг тогтоох, хэрэглэх хүрээ заагийн хязгаарлалтыг зөрчсөн бол торгох шийтгэл оногдуулахаар заажээ.</p> <p>Мөн зүйлд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тогтоосон хяналтын журам зөрчсөн, эсхүл үйл ажиллагааг нь түр зогсоосон тогтмол хэвлэлийг хэвлэлд бэлтгэсэн, үйлдвэрлэсэн, тараасан, худалдсан, борлуулсан бол торгох шийтгэл оногдуулахаар заажээ.</p> <p>Хуулийн 2.4 зүйлд төрийн албан ёсны хэлээр гарч байгаа олон нийтэд зориулсан хэвлэл, мэдээлэл нь орчин цагийн монгол утга зохиолын хэлний хэм хэмжээ, нэр томъёог баримтлах тухай журам зөрчсөн бол зөрчлийн хэрэгт тооцохоор хуульчилжээ.</p> <p>Зар сурталчилгааны тухай хуульд заасан зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхэд тавигдах нийтлэг шаардлагыг зөрчсөн, интернетээр түгээж байгаа зар сурталчилгаанд зар сурталчилгаа</p>

⁷⁵ Зөрчлийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэл №24 /981/

түгээгчийн холбогдох мэдээллийг тусгаагүй, хуулиар түгээхээр тусгайлан заасан сэрэмжлүүлгийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэвтрүүлгийн хөтөлбөрийг харгалзалгүйгээр холбогдох шийдвэрт заасан давтамжаар үнэ төлбөргүйгээр түгээгээгүй бол зөрчлийн хэрэгт тооцохоор хуульчилжээ. Үүний зэрэгцээ захиалагчаас өгсөн захиалга, даалгавар нь Зар сурталчилгааны тухай хуулийг зөрчиж байгааг түүнд урьдчилан мэдэгдээгүй, хүн, түүний нэр, алдар хүнд, эд хөрөнгө, уран бүтээлийг үзүүлэх, дүрслэх, хэлсэн үгнээс нь эшлэл татах, бусад хэлбэрээр ашиглахдаа тухайн хүн, өв залгамжлагч, эрх залгамжлагчийн зөвшөөрлийг урьдчилан аваагүй, нийтэд танил, нэр хүнд бүхий хуулийн этгээдийн нэр, бэлгэдэл, бүтээгдэхүүн, барааны тэмдэг, нэрийн товчлолыг зар сурталчилгаанд ашиглахад тухайн хуулийн этгээдийн зөвшөөрлийг урьдчилан аваагүй бол торгохоор заажээ.

Хуулийн 10.8 дугаар зүйлд аж ахуйн нэгж, байгууллага, банк, санхүүгийн үйл ажиллагааны нууцад хамаарах мэдээ, баримтыг хууль бусаар олж авсан этгээд ашигласан, эсхүл бусдад тараасан, задруулсан торгохоор заажээ.

Хуулийн 14.2 дугаар зүйлд радио төхөөрөмжийг тусгай зөвшөөрөлгүй, эрхийн бичиг аваагүй, бүртгэлгүйгээр ажиллуулсан зөрчлийн хэрэгт тооцохоор хуульчилжээ.

Хуулийн 15.1 дүгээр зүйлд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан, байгалийн гамшиг гэнэтийн бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн газарт хүрэлцэн очих, гэмт хэрэг, зөрчил гарсан тухай яаралтай мэдээллийг дамжуулахад тээвэр, холбоо, эсхүл мэдээллийн хэрэгслээ төрийн албан хаагч, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, хууль сахиулагчид ашиглуулахаас татгалзсан бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заажээ.

Хуулийн 15.14 дүгээр зүйлд төрийн болон албаны нууцад хамааруулах, төрийн болон албаны нууцтай танилцах, албаны нууцыг нууцлах, эсхүл ил болгох шаардлагыг зөрчвөл зөрчлийн хэрэгт тооцохоор хуульчилсан.

Хуулийн 15.31 дүгээр зүйлд Монгол Улсын Засгийн газрын албан ёсны нэр, бэлгэдлийг хэрэглэж худал мэдээлэл тараасан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан.

Хуулийн 17.1 дүгээр зүйлд сонгуулийн хорооноос мэдээлсэн санал хураалтын урьдчилсан дүнг илтэд гуйвуулсан, өөрөөр

мэдээлсэн, нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заажээ. Мөн сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй, хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргасан, эсхүл гаргахгүй байхаар амлалт авсан, гэрээ байгуулсан бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заажээ.

Хуулийн 6 дугаар зүйлд 6.18 дугаар зүйлд дараах хориглосон хэм хэмжээ тусгагджээ.

1.Зөвшөөрөлгүйгээр хэвлэл, ном, зохиол, зураг, кино, дүрс бичлэг бэлтгэх, тараах, борлуулах замаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Зөвшөөрөлгүйгээр хэвлэл, ном, зохиол, зураг, кино, дүрс бичлэг бэлтгэх, тараах, борлуулах зорилгоор улсын хилээр оруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Эротик сурталчилгаа, эсхүл үйлчилгээнд тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам зөрчсөн, эсхүл хуульд заасан эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйлийг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Уг хуулийн 16 дугаар зүйлд 16.7 дахь хэсэгт “харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн

	чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, 19 дүгээр зүйлд “Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргасан, эсхүл гаргахгүй байхаар амлалт авсан, гэрээ байгуулсан бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, 7 дугаар зүйлд “Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус заажээ.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Хуульд Сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалсан хэм хэмжээ тусгайлан зохицуулагдаагүй байна.

3.7 ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ⁷⁶

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах, хамгаалах, зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих, иргэн, хуулийн этгээдийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэй хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
эвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх</p> <p>9.1.2. хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;</p> <p>9.1.10. радио, телевизийн болон тэдгээрийг дамжуулах үйлчилгээний нөхцөл, шаардлагыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>19 дүгээр зүйл. Радио, телевизийн сүлжээ</p> <p>19.1. Радио, телевизийн сүлжээ нь радио болон телевизийн хөтөлбөрийг нэвтрүүлэх, хүлээн авах, дамжуулах тоног төхөөрөмж, техник хэрэгслээс бүрдэнэ.</p>

⁷⁶ Харилцаа холбооны тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/523?lawid=523>

	<p>19.2.Радио, телевизийн сүлжээг радио, телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөр бэлтгэх байгууллага үйлчлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглана.</p> <p>Мөн хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг хуульчилсан байна.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Хуульд Сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалсан хэм хэмжээ тусгайлан зохицуулагдаагүй байна.

3.8 РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ⁷⁷

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуульд зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь Монгол Улсын төрийн өмч мөн. Төр нь радио долгион өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, болзолтойгоор радио давтамж, радио давтамжийн зурвасыг ашиглах эрхийг бусад этгээдэд олгоно.</p> <p>Хуульд 8.1дэх хэсэгт зааснаар "Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй этгээд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглоно".</p> <p>Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана.</p> <p>Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл авах өргөдлийг хүлээн авмагц өргөдөл болон түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 10.1-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянана.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	<p>Сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулахдаа уг хуульд заасны дагуу радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах эрхтэй .</p> <p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ тусгагдаагүй.</p>

⁷⁷ Радио долгионы тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/443?lawid=443>

3.9 ШУУДАНГИЙН ТУХАЙ⁷⁸

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь шуудангийн сүлжээ, түүний ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Шуудангийн бүх нийтийн үйлчилгээнд үйлчлэгч нь байршил, хүргэх боломжоос үл хамааран Монгол Улсын нутаг дэвсгэр дэх нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллагад шуудангийн илгээмжийг тогтоосон хугацаанд хүргэх үйлчилгээ хамаардаг.</p> <p>Хэвлэл захиалгын үйлчилгээ болон хэвлэл мэдээллийн байгууллагуудаас гаргаж буй сонин, сэтгүүл зэргийг Монгол шуудан ТӨХК нь өөрийн 22 аймаг, 325 сум дахь шуудангийн салбар, УБ хотын 39 салбараар дамжуулан үйлчилдэг.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ тусгагдаагүй. Иймд сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаагаа хараат бусаар эрхлэх нэг үндэс нь түүний харилцаа холбоо, шуудангийн нууцлал зүй ёсоор ордог.

3.10 ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ⁷⁹

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуулийн 5.1.1 дугаар зүйлд “төрийн болон албаны нууцыг задруулах” гэж мэдээлэх, дамжуулах, үзүүлэх, хэвлэн нийтлэх болон бусад арга замаар төрийн болон албаны нууцтай танилцах эрхгүй этгээдэд хүрсэн байхыг ойлгохоор хуульчилжээ.</p> <p>Хуулийн 6.2-д зааснаар төрийн болон албаны нууцтай танилцсан Монгол Улсын төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, бусад хуулийн этгээд /цаашид “төрийн байгууллага, бусад хуулийн этгээд” гэх/, улс төрийн нам, хөдөлгөөн, төрийн бус байгууллага, албан тушаалтан, албан хаагч, Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн тэдгээрийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.</p>

⁷⁸ Шуудангийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2003 он №21/306/⁷⁹ Төрийн болон албаны нууцын тухай - "Төрийн мэдээлэл" эмхэтгэл 2017 он №11 /968/

<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй. Харин Сэтгүүлчийн үйл ажиллагааг хязгаарласан шинжтэй хэм хэмжээ агуулсан байна гэж судлаачид үздэг.</p> <p>Монгол Улсад хэвлэл мэдээллийн үйл ажиллагаатай холбоотой, хэвлэлийн эрх чөлөөг санаатай болон санамсаргүйгээр хязгаарлаж буй 50 гаруй хууль бий. Эдгээрээс дор хаяж 15 нь бүхлээрээ, эсхүл зарим хэсэг нь албан ёсны нууцтай холбоотой байдаг гэж судлаачид дүгнэсэн байна.⁸⁰</p> <p>Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын гол объектод төрийн нууц хамаардаг. Учир нь төрийн нууцтай холбоотой аливаа асуудал төрийн бодлогын нэг цөм гэж үздэг. Иймээс Үндсэн хуульд “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасан. Үүний дагуу төрийн нууц түүнд хамаарах аливаа мэдээ, мэдээллийг тусгайлан хуулиар жагсаалт хэлбэрээр хуульчилдаг байсан.</p> <p>Гэтэл 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж байгаа “Төрийн болон албаны нууцын тухай хууль” нь Үндсэн хуулийн дээрх зарчимд нийцэж байгаа эсэх нь эргэлзээтэй. Учир нь уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтад “Засгийн газар мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах эрхтэй”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална” гэж тус тус заасан нь Үндсэн хуульд төрийн нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасантай нийцэж байгаа эсэх асуудлыг эргэн авч үзэх шаардлагатай болж байна.</p> <p>Нөгөөтгээгүүр хууль тогтоох байгууллага төрөөс баримтлах аливаа бодлогыг тодорхойлж гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага түүнийг хэрэгжүүлдэг Үндсэн хуулийн зарчимтай нийцэж байгаа эсэх нь ч тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл Засгийн газар өөрөө бодлогоо тодорхойлоод өөрөө хэрэгжүүлээд явах нь зөв үү? Энэ байдал даамжирвал хэлмэгдүүлэлтийн үед гарсан шиг аймшигт нөхцөл байдалд хүргэх аюултай. Хуулиар бус хэн нэгэн байгууллага, албан тушаалтны шийдвэрээр гэм буруутай эсэхийг тогтоох эрх зүйн</p>

⁸⁰ Азийн Хэвлэл Мэдээллийн Барометрийн тухай МОНГОЛ УЛС 2012,19 тал

	<p>орчин бүрдэнэ. Эсвэл улс төрийн зорилгоор аливаа үйл ажиллагааг нууцлах явдал үзэмжийн асуудал болно.</p> <p>Үндсэн хуульд “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж заасан нь олон нийтийн мэдэх эрхийг баталгаажуулсан Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт.</p> <p>Гэтэл Үндсэн хуульд заасан эрхийг хэн нэг албан тушаалтан ялангуяа гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага тушаал, шийдвэр гаргаж төрийн болон албаны нууц гэж хязгаарлахад хүргэж байна. Энэ нь хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг дордуулсан эрх зүйн зохицуулалт гэж дүгнэхэд хүргэж байна. Нөгөөтгээгүүр сэтгүүлчдийг төрийн болон албаны нууц задруулсан этгээд болгох эрсдэлд хүргэнэ.</p> <p>Иймд төрийн нууцын асуудлыг хууль тогтоогчид эргэн харж Үндсэн хуульд заасны дагуу хуульчлан тогтоодог байхаар уг хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах нь төрийн хийгээд түмний ашиг сонирхолд бүрэн нийцнэ.⁸¹</p>
--	--

3.11 ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛЬ⁸²

<p>Хуулийн зорилт</p>	<p>Энэ хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>
<p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Хуулийн 18 дугаар зүйлд заасан тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх/-ээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хүчинтэйд тооцно гэж заасан.</p> <p>Цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нь цаасан тээгч дээрх баримт бичиг солилцохоос эрс ялгаатай. Ажил хэргийн харилцаа, төрийн удирдлагад цахим хэлбэрээр өгөгдөл, баримт бичиг солилцох ажиллагааг нэвтрүүлснээр маш олон давуу тал, хэмнэлт гардаг боловч түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах, илгээсэн этгээдийг хөдөлбөргүй адилтган тогтоох асуудал урган гардаг. Энэ асуудлыг тоон гарын үсгийн хэрэгслүүд ашиглаж шийддэг байна. Дэлхийн улсуудад тоон гарын үсгийн хэрэглэх асуудлыг 1990 оноос эхлэн хуульчлан зохицуулсан байдаг.</p>

⁸¹ <https://pikas.mn/2018/11/19>

⁸² Цахим гарын үсгийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2012 он №1 (718)

	<p>Орчин үед хэвлэл мэдээллийн салбар дахь цахим хэрэгцээ шаардлага ихээхэн бий болж байна. Цахим засаг, цахим бизнес, цахим нийгэм, мэдээллийн технологийн хөгжлийг ашиглах, цахим өгөгдөл солилцох зэрэг нь энэ тэргүүний хэрэгцээ болж байна.</p> <p>Төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн бодлого боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй болгож, цахим засгийн үйлчилгээг хөгжүүлж нэвтрүүлэх зорилгоор “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа билээ.</p> <p>Үүнтэй холбоотойгоор цахим тоон гарын үсэг ашиглах үед эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд цоо шинэ эрх, үүрэг үүсэж, тоон гарын үсгийн үнэн зөвийг баталгаажуулах тусгай байгууллагууд байгуулагддаг. Эдгээр байгууллагад тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл, эрх үүргийг энэ хуулиар хуульчлан тогтоосон.</p>
<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.</p>

3.12 ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ⁸³

<p>Хуулийн зорилт</p>	<p>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээх, түүнд хяналт тавих болон шударга өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p>
<p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ:</p>	<p>Хуульд зааснаар ”зар сурталчилгаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагааны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг ойлгоно. Мэдээлэх хэрэгсэл гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерын сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгслийг хамааруулдаг.</p> <p>Хэвлэл мэдээллийн хэрэгслийн санхүүгийн үндсэн эх үүсвэр нь зар сурталчилгаа юм. Уг хуульд зар сурталчилгаа, түүнд тавих ерөнхий шаардлага, хориглох зүйлийг хуульчилсан.</p>

⁸³ Зар сурталчилгааны тухай - <https://www.legalinfo.mn/law/details/259?lawid=259>

Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.
--	--

3.13 АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ⁸⁴

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Энэ хуулийн 17.3-т заасны дагуу Засгийн газраас баталсан талбайн солбицлын хүрээнд төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялгаж, сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.</p> <p>Лиценз (тусгай зөвшөөрөл), лиценз хуваарилалтын ил тод байдал, орон нутагт явагдаж байгаа уул уурхайн ажлуудын хамгийн ерөнхий мэдээллийг өгөх үүрэг хэрэгжихгүй байх, нутгийн иргэд лиценз олгох үйл явц, уул уурхайн лицензтэй холбоотой орон нутгийн газрын хэсэг, ирээдүйд уул уурхайн олборлолт явуулахаар төлөвлөж, хуваарилсан орон нутгийн газрын хэсэг, олборлолтын лиценз олголтоос өмнөх орон нутгийн зөвлөлдөх үйл явц, лиценз шилжүүлэлт, лицензийн төлбөр, лицензийн асуудлуудын тухай нарийн мэдээлэл олж авах суваг зэргийн мэдээлэл ямагт дутмаг байдаг.</p> <p>Энэ төрлийн мэдээллийг бүрэн хэмжээгээр ил болгох явдал нь нэг талаас иргэдийн мэдэх эрх, нөгөө талаас хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг юм.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.14 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ⁸⁵

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй үялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг
-----------------------	---

⁸⁴ Ашигт малтмалын тухай - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2006 он №30/459/

⁸⁵ Байгаль орчныг хамгаалах тухай – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1995 он №5-6/36-37/

	сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуулийн 56 дугаар зүйлд Засгийн газар албан болон албан бус боловсролын тогтолцооны хүрээнд иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил, байгаль орчныг хамгаалах арга, дадал олгох хөтөлбөрийг баталж биелэлтийг зохион байгуулна гэж заасан.</p> <p>Экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дараах байдлаар зохион байгуулна: Үүнд:</p> <p>1/ сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуульд байгаль орчныг хамгаалах анхны мэдлэг, хүмүүжил олгох;</p> <p>2/ коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагад мэргэжлийн чиг баримжааг харгалзан байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах шинжлэх ухааны үндэс, эрх зүйн мэдлэг олгох;</p> <p>3/ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомж сурталчлах.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй

3.15 БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ⁸⁶

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь байгууллагын нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
-----------------------	---

⁸⁶ Байгууллагын нууцын тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1995 он №7 (38)

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуульд зааснаар байгууллагын нууцыг хариуцаж байгаа, эсхүл түүнтэй албан үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны дагуу танилцсан, олж мэдсэн этгээд уул нууцыг чанд хадгалах үүрэгтэй.Хуулийн 6 дугаар зүйлд нууцлахыг хориглох мэдээллийн хүрээг тодорхойлсон бөгөөд байгууллага дор дурдсан мэдээллийг нууцалж болохгүй:</p> <p>1/ тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл;</p> <p>2/ тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл;</p> <p>3/ гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл.</p> <p>Байгууллагын нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн этгээд уул нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.</p> <p>Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.16 БОЛОВСРОЛЫН ТУХАЙ⁸⁷

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	Хуулийн 42 дүгээр зүйлийн 42,2 дахь хэсэгт сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага өөрийн харьяа хэвлэл, мэдээлэл, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг засварлах, үйлдвэрлэх, хангах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгжтэй байж болно гэж заасан.

⁸⁷ Боловсролын тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/9020?lawid=9020>

Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.
--	--

3.17 ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ⁸⁸

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь гадаадын иргэний эрх зүйн байдлыг тогтоож, гадаадын иргэн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суухтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	Хуулийн 13 дугаар зүйлд албан зэргийн визийг гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн байгууллагын албан болон энгийн паспорттай ажилтанд олгохоор заасан. Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн болон гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус улсад оршин суух зөвшөөрөл олгож, хугацааг нь сунгана” гэж заажээ.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.18 ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ⁸⁹

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	Хуулийн 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна”, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь хэсэгт “гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар зарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол, шуурхай, хүртээмжтэй, дэлгэрэнгүй мэдээлэх, хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь хэсэгт “гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн

⁸⁸ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2010 он №32 (653)

⁸⁹ Гамшгаас хамгаалах тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/12458?lawid=12458>

	хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах” тухай тус тус заажээ.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.19 ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ⁹⁰

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг тогтооход оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуулийн 32 дугаар зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүргийг хуульчилсан.</p> <p>Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээ, сурвалжилга хийх, нэвтрүүлэг бэлтгэхдээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг олон нийтэд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгоно” гэж, хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлнэ” гэж, 32.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 32.2-т заасан хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална”, 32.4 дэх хэсэгт “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль ёсны аргаар хамгаалах арга замыг тодорхой тусгаж хэрэгжүүлнэ” гэж, 32.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 32.4-т заасан агуулга бүхий нийтлэл, мэдээллийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, нийтэлж байгаа нийт мэдээлэлд эзлэх хувь, заавал нэвтрүүлбэл зохих нийтлэл, мэдээллийн доод хэмжээг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж тус тус заажээ.</p> <p>Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсэгт “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх</p>

⁹⁰ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2019 он №42 (1095)

	аргыг нарийвчлан харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, түүний ул мөрийг нуун далдлах арга, хэрэгслийг нарийвчлан дүрсэлсэн, гэмт хэрэг, зөрчлийг ашиг, орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгон харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдэл төрүүлж болох агуулгатай аливаа мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхийг хориглоно” гэж, уг зүйлийн 32.7 дахь хэсэгт “Шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай болон гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно” гэж, 32.8 дахь хэсэгт ”Хэвлэл, мэдээллийн байгууллага гэмт хэргийн шинжтэй, илт хууль бус нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгааны тухай асуудлыг цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй” гэж, 32.9 дэх хэсэгт “Гэрч, хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний нүүр царай, дуу хоолойг танигдахуйц байдлаар гаргах, хувийн байдалтай холбоотой мэдээллийг тараах, хохирогчийг буруутгасан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийхийг хориглоно “ гэж тус тус заажээ.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.20 ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ⁹¹

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	Хуулийн 36 дугаар зүйл. Хувьчлах хөрөнгийн талаар мэдээлэл хүргэх Хувьчлагдах төрийн өмчит хуулийн этгээд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хувьцаа, ногдол хувьтай холбогдох мэдээллийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хувьчлах үйл ажиллагаа эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө төр, засгийн газрын албан ёсны хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд сонордуулна.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

⁹¹ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1996 он №11(54)

3.21 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ⁹²

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	Хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Гэр бүлийн хүчирхийллийг сурталчилсан, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно” гэж заасан.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй

3.22 ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ⁹³

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь тайван жагсаал, цуглаан хийх иргэдийн Үндсэн хуулийн эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал цуглаан хийх журмыг тогтоох, уул арга хэмжээний үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	Хуулийн 13 дугаар зүйлд “ Нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий байгууллага нь энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалж, түүнд оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах үүрэгтэй” мөн зүйлийн 3 дахь хэсэгт “ Жагсаал, цуглаан зохион байгуулагч болон оролцогчид нь хэв журам, хууль ёсыг сахих талаар цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй” гэжээ.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй

⁹² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017 он №05 (962)

⁹³ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1994 он №09 (28)

3.23 ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ⁹⁴

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	Хуулийн 2 дугаар зүйлд 2.1.2 дахь хэсэгт “залуучуудыг гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэгт “залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь хэсэгт “олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах, эрүүл, зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах “ гэж тус тус заажээ.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.24 ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН ТУХАЙ⁹⁵

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
-----------------------	---

⁹⁴ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017 он №29 (986)

⁹⁵ Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2006 он №7 (436)

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуулийн 22 дугаар зүйлд Радио, телевизийн байгууллагын эрхийг хуульчилсан.</p> <p>Хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Радио, телевизийн байгууллага өөрийн нэвтрүүлэгтэй холбоотой дараах үйл ажиллагааг хориглох болон зөвшөөрөх онцгой эрхтэй:</p> <p>22.1.1.нэвтрүүлгийн бичлэг хийх;</p> <p>22.1.2.нэвтрүүлгийн бичлэгийг хуулбарлах;</p> <p>22.1.3.нэвтрүүлгийг утсан бус холбоо ашиглах замаар дахин дамжуулах;</p> <p>22.1.4.нэвтрүүлгийг нэгэн зэрэг дамжуулах.</p> <p>22.2.Радио, телевизийн байгууллагын нэвтрүүлгийн эрхийн хамгаалалтын хугацаа уг нэвтрүүлгийг анх нэвтрүүлсний дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна” гэж тус тус заажээ.</p> <p>24 дүгээр зүйл. Зохиогчийн эрхийн зөрчилд тооцохгүй байх онцгой нөхцөлүүд</p> <p>24.1.Нийтлэгдсэн бүтээлийн зүй ёсны ашиглалттай зөрчилдөөгүй, эрх эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр ашигласан дараах тохиолдлыг зохиогчийн эрхийн зөрчилд тооцохгүй:</p> <p>24.1.1.хэвлэлийн тойм бэлтгэх зорилгоор нийтлэгдсэн бүтээлээс ишлэл авах;</p> <p>12 дугаар зүйл. Бүтээл ашиглах онцгой эрх</p> <p>12.1.Зохиогч нь өөрийн бүтээлийг бүхий л арга, хэлбэрээр ашиглах онцгой эрх эдэлнэ.</p> <p>12.2.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхэд зохиогч дараах үйл ажиллагааг зөвшөөрөх болон хориглох онцгой эрхийг хамааруулна:</p> <p>12.2.1.бүтээлийг хуулбарлах;</p> <p>12.2.2.бүтээлийг нийтлэх;</p> <p>12.2.3.бүтээлийг нийтэд түгээх;</p> <p>12.2.4.үүсмэл бүтээл болгон өөрчлөх;</p> <p>12.2.5.түрээсээр ашиглуулах.</p> <p>12.3.Энэ хуулийн 12.1 дэх хэсэгт заасан эрхийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлөөр, гэрээний үндсэн дээр бусад этгээдэд шилжүүлнэ.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.25 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ⁹⁶

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгааг тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын орчныг тогтворжуулах, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох болон хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Дараах салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авна: 21.1.1.уул уурхай; 21.1.2.банк, санхүү; 21.1.3.хэвлэл, мэдээлэл, харилцаа холбоо” гэж заажээ.Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар хуульчилсан нь өмнөх хуулийнхаа үзэл баримтлалыг уламжлан авсан зохицуулалт болсон.Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн салбарыг үндэсний аюулгүй байдалтай холбоотойгоор стратегийн ач холбогдол бүхий салбарт тооцсон хуулийн зохицуулалт хэвээр байгаа юм.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.26 АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ⁹⁷

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах /үйлчлэх/, хэрэглэх, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	9 дүгээр зүйл. Архидан согтуурахын эсрэг сурталчилгаа 9.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй. 9.2. Дараах хэлбэрээр согтууруулах ундаа сурталчлахыг хориглоно:

⁹⁶ Хөрөнгө оруулалтын тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2013 он №41 (806)

⁹⁷ Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №6 (143)

	<p>9.2.1. согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэт, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар гаргах;</p> <p>10 дугаар зүйл. Стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааг нийтэд мэдээлэх</p> <p>10.1. Эрх бүхий байгууллагын шалгалт, шинжилгээгээр хүний амь нас, эрүүл мэндэд хортой болох нь тогтоогдсон, стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны хор хөнөөлийн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд шуурхай зарлан мэдэгдэнэ.</p> <p>10.2. Стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны хор хөнөөлийн талаарх мэдээллийг бүх төрлийн хэвлэл мэдээллийн байгууллага саадгүй хүлээн авч, нийтэд түгээх үүрэгтэй.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.27 КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ⁹⁸

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал /цаашид “цар тахал” гэх/-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуулийн 14 дүгээр зүйлд Хэвлэл мэдээллийн байгууллагын үүргийг хуульчилжээ.</p> <p>Мөн зүйлийн 14.1 дэх хэсэгт “Хэвлэл мэдээллийн байгууллага цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Улсын онцгой комисс болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн сэрэмжлүүлэг, мэдээллийг олон нийтэд үнэ төлбөргүй, саадгүйгээр мэдээлнэ” гэж, 14.2дахь хэсэгт “ Цар тахлын талаарх цаг үеийн болон түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой үнэн, бодит мэдээллийг</p>

⁹⁸ Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №17 (1119)

	<p>баталгаатай эх сурвалжаас авч олон нийтэд хүргэнэ” гэж тус тус заасан.</p>
<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.</p> <p>Хэвлэл мэдээллийн зөвлөл, Глоб интернэшнл төвтэй хамтран УИХ-аар уг хуулийн төслийг хэлэлцэхтэй холбогдуулан доорх саналыг хүргүүлж байжээ.</p> <p>Коронавируст халдвар /covid-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн төслийн 14.2-р зүйл “цар тахлын талаарх цаг үеийн болон цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотой үнэн бодит, мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авч олон нийтэд хүргэнэ” гэсэн заалт нь сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хэвлэл мэдээллийн байгууллагуудын редакцын агуулгад төрөөс чанарын хяналт тогтоох гэсэн оролдлого хэмээн үзэж буй тул “үнэн бодит мэдээлэл”, “баталгаатай эх сурвалж” гэсэн томъёоллын тайлбарыг оруулж, урвуулан ашиглахаас сэргийлэх.</p> <p>Мөн хуулийн 9.14-т “... олон нийтийг төөрөгдүүлсэн мэдээ мэдээллийг таслан зогсоох зорилгоор цахим хуудас болон олон нийтийн сүлжээний хяналтыг түр хязгаарлах, тархалтыг бууруулах арга хэмжээг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн нэн даруй авна”, 9.15-т “... зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаах, шаардлагатай тохиолдолд мэдээллийг саадгүй гаргах үүрэг хүлээнэ”, 9.16-т “төөрөгдүүлэх, худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага, ХХЗХ-той хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавина” гэсэн заалтууд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мөн редакцын нууц эх сурвалжийн хамгаалалт зэрэг үндсэн эрхүүдийг хязгаарлаж, цензур тогтоож болзошгүй, урвуулан болон хэтрүүлэн ашиглагдах боломжтой тул, хариуцлагын ямар хориг арга хэмжээ авахаар төлөвлөж буйг тодорхой болгох (тух: торгууль, хориг тавих, лицензийг хураах, хэвлэн нийтлэхийг хориглох, редакцын агуулгыг устгах гэх мэт), мөн “төөрөгдүүлэх мэдээ”, “худал мэдээ” зэргийг тодорхойлох, хуульд тайлбар хийх замаар урвуулан ашиглагдахаас сэргийлэх.</p> <p>Гамшгаас хамгаалах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 10.4.13. “Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэргэсэл болон нийгмийн сүлжээнд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг түр зогсоох, хязгаарлах” гэсэн заалт нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакттай зөрчилдөж буй ноцтой заалт тул хуулийн төслөөс хасах.</p>

	<p>Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 5.13.1. “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюул, нийгэмд үүссэн бусад эрсдэлийн үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн бол хүнийг 500,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 5 сая төгрөгөөр торгоно” гэсэн заалт нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлийн хязгаарлалтын хүрээг өргөжүүлжээ. Ингэснээр дээрх заалт нь олон улсын стандартын зөвшөөрсөн хэм хэмжээнээс илүүгээр хүлээн зөвшөөрөгдөх, онцгой байдал үүссэн тохиолдолд онцын шаардлагагүйгээр хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах, цензур тогтоох эрсдэлийг дагуулж байна. Мөн торгуулийн хэмжээг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн 13.14 “Худал мэдээ тараах” заалтын торгуулийн хэмжээтэй уялдуулж бууруулах.⁹⁹</p>
--	--

3.28 УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ¹⁰⁰

<p>Хуулийн зорилт</p>	<p>Энэ хуулийн зорилт нь улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх, төлөх, хураах болон түүнийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>
<p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ:</p>	<p>30 дугаар зүйл. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ</p> <p>30.1. Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 200 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.</p> <p>30.2. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:</p> <p>30.2.1. Ярианы үйлчилгээ эрхлэхэд 1 000 000 төгрөг;</p> <p>30.2.2. Интернэт, өгөгдөл дамжуулах үйлчилгээ эрхлэхэд 40 000-100 000 төгрөг;</p> <p>30.2.3. Телевиз, радиогийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэхэд 32 000-80 000 төгрөг;</p> <p>30.2.4. Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд 20 000-50 000 төгрөг;</p> <p>30.2.5. Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэхэд 20 000-50 000 төгрөг;</p> <p>30.2.6. Дамжуулан хүргэх, нэмэлт үйлчилгээ эрхлэхэд 12 000-30 000 төгрөг.</p> <p>30.3. Контентын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:</p> <p>30.3.1. Телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 20 000-50 000 төгрөг, аймагт 15 000-20 000 төгрөг;</p> <p>30.3.2. Радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 15 000-40 000 төгрөг, аймагт 6000-15 000 төгрөг;</p>

⁹⁹ <http://www.mediacouncil.mn/a/166>

¹⁰⁰ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2011 он №1 (670)

	<p>30.3.3.Кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 20 000-50 000 төгрөг, аймагт 10000-20 000 төгрөг;</p> <p>30.3.4.Тусгай дугаар ашигласан мэдээлэл, лавлагааны үйлчилгээ эрхлэхэд 10000-20 000 төгрөг;</p> <p>30.3.5.Контент агрегаторын үйлчилгээ эрхлэхэд 20 000-50 000 төгрөг.</p> <p>30.4.Бүртгэлийн гэрчилгээ олгоход 10000-20 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.</p> <p>30.5.Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 10000-25 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

3.29 АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ¹⁰¹

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Хуульд олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тодорхойлохдоо “ олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолбор “ гэжээ.</p> <p>Энэ үйл ажиллагааны хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулахаар заасан.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Хуульд авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ тусгайлан зохицуулагдаагүй байна.

¹⁰¹ Авлигын эсрэг хууль – “Төрийн мэдээлэл ” эмхэтгэл 2006 он №35 (464)

3.30 МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ¹⁰²

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	<p>Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.</p> <p>Хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар “иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглодог. Мөн бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол гэм буруутай этгээд няцаах үүрэг хүлээдэг. Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.</p> <p>Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.</p> <p>Мөн хуулийн 497 дугаар зүйлд бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй. Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө гэж заасан,</p> <p>Хуульд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах чиглэлээр тусгайлсан харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бөгөөд бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүргийг хуульчилжээ.</p>
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулахдаа уг хуульд заасны дагуу нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалуулж өөрт учирсан гэм хороо арилгуулахыг шаардах эрхтэй .

¹⁰² Монгол Улсын Иргэний хууль - <https://www.legalinfo.mn/law/details/299?lawid=299>

3.31 АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ¹⁰³

<p>Хуулийн зорилт</p>	<p>Энэ хуулийн зорилт нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад оршино.</p>
<p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>19.12.Сонгуулийн хорооны хуралдаанд сонгуульд оролцож байгаа нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, ажиглагчдыг байлцуулж болно. Хуралдааныг ажиглах, дуу болон дүрс бичлэг хийх боломжоор хангах асуудлыг хуралдааны дэгээр зохицуулна.</p> <p>38.5.Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага нь сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлнэ.</p> <p>45.19.Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй.</p> <p>47.8.Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.</p> <p>47.14.Шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагад эхний удаа сануулах арга хэмжээг авч болно.</p> <p>64.12.Санал авах ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг байлцуулж болно.</p> <p>70.16.Хяналтын тооллого хийх ажиллагаанд ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно.</p>
<p>Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ</p>	<p>Хуульд Сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалсан хэм хэмжээ тусгайлан зохицуулагдаагүй байна.</p>

¹⁰³ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №08 (1110)

3.32 АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ¹⁰⁴

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	15.16. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр: 15.16.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах; 15.16.2. харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх. 15.16.3. контентын үйлчилгээ эрхлэх. 15.16.4. тоон гарын үсгийн гэрчилгээ олгох. 15.16.5. радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ; 15.16.6. радио, телевизийн үйлчилгээ: 15.16.6.а. олон нийтийн радио, телевиз; 15.16.6.б. арилжааны радио, телевиз; 15.16.6.в. өргөн нэвтрүүлгийн радио, телевиз; 15.16.6.г. төлбөртэй радио, телевиз. 15.16.7. олон суваг дамжуулах үйлчилгээ.
Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Хуульд Сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалсан хэм хэмжээ тусгайлан зохицуулагдаагүй байна.

3.33 АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ¹⁰⁵

Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь ард нийтийн санал асуулга /цаашид "санал асуулга" гэх/ явуулах зарчим, журмыг тодорхойлж, санал асуулгыг бэлтгэн зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ	16.5. Санал асуулга явуулах ажиллагаанд ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно. 19.1. Хэсэгт санал тоолох ажиллагааг санал асуулга явуулах өдрийн 22.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын болон иргэний төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.

¹⁰⁴ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль – <https://www.legalinfo.mn/law/details/34?lawid=34>¹⁰⁵ Ард нийтийн санал асуулгын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэл 2016 он № 09 /918/

Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ	Сэтгүүлчийн хараат бус байдлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй.
--	--

3.34 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ¹⁰⁶

Хуулийн зорилт	<p>Энэ хуулийн зорилт нь хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>Энэ хуулийн дагуу хэвлэл мэдээллийн байгууллага шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд мөрдөх юм.</p>
-----------------------	--

¹⁰⁶ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэл 2018 он № 30 /1035/

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

4.1 Судалгааны үр дүн

"Хэрэв хэвлэлгүй засаг эсвэл засаггүй хэвлэл хоёрын хооронд сонгох шаардлага надад гарсан бол би хором ч эргэлзэлгүй хэвлэл мэдээллийг сонгох болно." Томас Жефферсон

Монгол Улс 2020 онд хэвлэлийн эрх чөлөөний индексээр “Хагас эрх чөлөөтэй” орны тоонд багтаж байгаа нь чөлөөт хэвлэл төлөвшөөгүй, сэтгүүлчид хараат бусаар үйл ажиллагаагаа эрхэлж чадахгүй байгаагийн илрэл юм. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь сэтгүүлчид үйл ажиллагаагаа явуулахдаа бие даасан хараат бусаар эрхлэн явуулах боломж бүрдсэн тохиолдолд л хэрэгждэг.



Иймээс сэтгүүл зүйн салбарт сэтгүүлчийн хараат бус байдал хэрхэн хангагдсан талаар судлах явдал нь судалгааны ажлын хүрээнд нэн тэргүүнд тавигдсан. Учир нь энэ чиглэлээр дагнан хийгдсэн судалгааны ажил хараахан гараагүй байна. Харин уг асуудал нь зарим судалгааны байгууллагуудаас хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хүрээнд хийгдсэн судалгаанд цухас дурдагдаж байгаагаас үзвэл сэтгүүлчийн хараат бус байдлыг эрх зүй, эдийн засаг, улс төр, сэтгүүл зүйн мэргэжлийн үүднээс тал бүрээс нь авч үзэж судлах онолын хийгээд практик ач холбогдолтой болохыг харуулж байна.

Олон улсын сэтгүүлчдийн холбооноос “Хараат бус хэвлэл, мэдээллийн хэрэгсэл гэдэг нь Засгийн газар, улс төрийн болон эдийн засаг, дэд бүтцээс хараат бус байх явдал гэж үзнэ” хэмээн

томъёолжээ. Олон улсын сэтгүүлчдийн холбооны гол баримт бичигт “Хэрвээ сэтгүүлчид авлига, ядуурал, айдас дунд байвал тэнд хэвлэлийн эрх чөлөө байхгүй” хэмээн онцолсон.

Сэтгүүлчийн бусдаас хараат бус байх явдал нь эрх чөлөөний асуудал боловч уг эрх чөлөөг хуульчлан баталгаажуулаагүй бол тунхаглал төдий зүйл болно. Манай улсад сэтгүүлчдийн мэргэжлийн эрхэд халдсан нийт зөрчлийн дийлэнх хувийг “мэдээлэл өгөхөөс татгалзсан буюу мэдээлэл олж авах, түгээхэд саад хийсэн”- 25%, “Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан”-17%, “Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан”-16% эзэлж байна. Мөн судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 51.2%-ыг нууц эх сурвалжаа илчлэхийг албадаж байжээ.¹⁰⁷

Хараат бус байдал нь хуулиар хамгаалагдаагүй тохиолдолд тал бүрийн дарамт шахалтын улмаас сэтгүүлч мэргэжлийн ажлаа гүйцэтгэж чадахгүйд хүрнэ. Зарим судалгаагаар нийт сэтгүүлчдийн 50 хувь буюу хоёр сэтгүүлч тутмын нэг нь хараат бусаар ажиллаж чаддаггүй бол 54.5 хувь нь өөрийн бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлгээ олон нийтэд чөлөөтэй түгээж чаддаггүй гэсэн дүн гарчээ.

Иймд хуулийн хүрээнд эрхээ хамгаалуулах нь сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах үндсэн нөхцөл юм. Олон улсын практикт сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах, хамгаалах чиглэлээр хууль тогтоомжууд баталсан сайн жишээнүүд бий. Тухайлбал, Швейцарын холбооны улсын “Телевиз, радиогийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд “сэтгүүлчийн хараат бус, бие даасан байдал”-ын талаар хуульчилсан бөгөөд уг хуулийн 6.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол аливаа төрийн байгууллага нь сэтгүүлчид болон хэвлэлийн байгууллагын үйл ажиллагаанд оролцохгүй”, 6.2 дахь хэсэгт “сэтгүүлч өөрийн программ, нэвтрүүлгийн утга, агуулгыг өөрөө сонгох эрхтэй бөгөөд дээрх мэдээлэлтэй холбоотой асуудлыг хариуцна” хэмээн хуульчилжээ.

Мөн хуулийн 12 дугаар зүйл 12.1 дэх хэсэгт “захиалгат нэвтрүүлгийн утга, агуулгатай холбоотой хариуцлагыг тухайн хэвлэлийн байгууллага хариуцах бөгөөд захиалагч болон санхүүжүүлэгч нь редакцын бие даасан байдалд нөлөөлөхүйц байдлаар оролцохгүй” гэжээ. Эндээс харахад сэтгүүлч нь өөрсдийн хариуцсан мэдээ, нийтлэлийн утгыг хэн нэгнээс хараат бусаар, бие даан шийдэх эрхтэй байхаар хуульчлан баталгаажуулжээ.

Сэтгүүлчийн хараат бус байдлыг хууль гарган хамгаалсан сайн туршлагын тоонд Бүгд Найрамдах Узбекистан улсын жишээг дурдаж болно. Тус улсын хууль тогтоох байгууллагаас сэтгүүлчийн хараат бус байдлыг тусгайлан бие даасан хууль батлах замаар шийдвэрлэсэн байна.

1997 онд батлагдсан Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах тухай хуулийн зорилго нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

¹⁰⁷ Глоб интернэшнл ТББ-ын судалгаа (2020 оны 5 сар)

Хуульд Сэтгүүлчийн хараат бус байдлыг дараах байдлаар хуульчлан хамгаалсан байна.

Үүнд:

1/хуулийн 5 дугаар зүйлд “эрэн сурвалжлах сэтгүүл зүй эрхлэх”, “олон нийтийн мэдээллийн хэрэгслээс даалгасан ажил нь хууль зөрчсөн бол хийхээс татгалзах”, “бэлтгэсэн мэдээ мэдээлэл, материалаа өөрийн гарын үсэг, нууц нэрээр түгээх, түүгээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх”, “бэлтгэсэн мэдээ мэдээлэл, материалыг засварлахдаа агуулгыг нь гажуудуулсан гэж үзвэл түүнд гарын үсэг зурахгүй байх, түүнийг олон нийтэд хэвлэн нийтэлж нэвтрүүлэхгүй байхыг шаардах”, “сэтгүүлчийн бэлтгэсэн материалыг хэвлэн нийтлэхдээ агуулгыг нь гажуудуулж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэлсэнтэй холбоотойгоор түүнд учирсан сэтгэл санааны /ёс суртахууны /болон эд хөрөнгийн хохирлыг /шүүхийн журмаар/нөхөн төлүүлэх/шаардах/ээр шүүхэд нэхэмжлэл гаргах” зэрэг эрхийг хуульчилсан.

2/ Сэтгүүлч мэргэжлийн үүргээ гүйцэтгэхдээ хувийн халдашгүй байдлын баталгааг эдэлнэ.

3/Шүүмжтэй материал нийтэлснийх нь төлөө сэтгүүлчийг дарамтлах, мөрдөн шалгахыг зөвшөөрөхгүй зэргээр сэтгүүлчдийн эрхийг хамгаалсан байна.

Монгол Улсад нийт 770 гаруй хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хуулиудаас сэтгүүлчийн үйл ажиллагаатай шууд холбогдсон харилцааг зохицуулсан хэм хэмжээ 40 орчим хуульд тусгагдсан бол шууд бусаар 60 гаруй хуулиар уг харилцааг хуульчлан зохицуулсан байна.

Монгол Улс Үндсэн хуулиар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх зэрэг суурь эрхийг баталгаажуулсан билээ. Мөн түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг олон улсын гэрээ, баримт бичгийг соёрхон баталсан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалд төрөөс хэвлэл мэдээллийн салбарт баримтлах бодлогыг тодорхойлсон зарим зүйлийг гуравдугаар зүйлд дараах байдлаар баталгаажуулсан байна. Үүнд:

1/Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2/Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд мэдээлэл олж авах, мэдээллийн эх сурвалжийг нууцлах талаар хуульчилсан. Уг зүйлийн 1 дэх хэсэгт “Олон нийтийн радио, телевизийн ажилтан төр, байгууллага болон хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг олж авах, нийтийн хүртээл болгох эрхтэй” гэж заасан. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт 34.2 “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан нь

Сэтгүүлчийн хараат бус байдлыг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн боловч энэхүү эрх зүйг зохицуулалт нь зөвхөн Олон нийтийн радио, телевизийн ажилтанд л хамаардаг.

Үүнээс үзвэл олон нийтийн радио, телевизээс бусад хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж буй сэтгүүлчийн хараат бус байдлыг хуулиар тусгайлан хамгаалж хуульчлаагүй байгаа юм.

Иймд сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр бие даасан хууль батлан гаргах шаардлага практикаас урган гарч байна. Уг хуулиар сэтгүүлчийн эрх, үүрэг, эх сурвалжаа нууцлах эрх, сэтгүүлчийг мэдээллийг чөлөөтэй олж авах, түгээх баталгааг бүрдүүлж, мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэх хамгаалалтыг баталгаажуулах, төрөөс сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, мэргэжлийн үүргээ гүйцэтгэхдээ олж авсан аливаа мэдээллийг түүнээс шаардан авахыг хориглох, эрэн сурвалжлах үйл ажиллагаа эрхлэх, мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан мөрдөн байцаахгүй байх зэрэг зохицуулалтыг хуульчлан тусгах боломж бүрдэх юм. Ингэснээр сэтгүүлч хараат бусаар мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэн явуулах эрх зүйн орчин бүрдэнэ.



Wondershare
PDFelement

4.2 ХУУЛИЙН ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

СЭТГҮҮЛЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАМГААЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах тухай хууль тогтоомж

2.1. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Сэтгүүлч

3.1. Сэтгүүлч гэж хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хөдөлмөрийн болон бусад гэрээний үндсэн дээр ажиллаж олон нийтэд зориулж материал цуглуулах, дүн шинжилгээ хийх, засах, бэлтгэх, түгээх үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг сэтгүүлч гэнэ.

4 дүгээр зүйл. Хяналт тавихыг хориглох Мэдээлэлд хяналт тавихыг хориглох

4.1. Монгол Улсад сэтгүүлч болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тавихыг хориглоно.

4.2. Сэтгүүлчээс хэвлэн нийтлэх мэдээ мэдээлэл, бусад материалыг/ агуулгыг/ урьдчилан тохиролцохыг шаардах, мөн түүнчлэн эхэд нь өөрчлөлт оруулах, хэвлэлтээс /нэвтрүүлэхээс/бүрэн хасахыг шаардах эрх хэнд ч байхгүй.

4.3. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус, бусад аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч Сэтгүүлчийн үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

4.4. Сэтгүүлчээс хэвлэн нийтлэх мэдээ мэдээлэл, бусад материалыг болон хэвлэн нийтэлсэн зүйлийнх нь талаар өөрийг нь холбогдуулан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан тайлбар, мэдүүлэг авахаар шаардахыг хориглоно.

4.5. Сэтгүүлч нь сэтгүүлчийн мэргэжлийн байгууллагаас бусад этгээдэд аливаа материал танилцуулах үүрэг хүлээхгүй.

4.6. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

4.7. Төрөөс сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.

5 дугаар зүйл. Сэтгүүлчийн эрх

- 5.1. Сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулахдаа дараах эрх эдэлнэ:
мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, засах, бэлтгэх, түгээх;
- 5.2. төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээд бусад этгээдээс мэдээлэл олж авах/аар хандах/
- 5.3. төрийн нууц болон хуулиар хамгаалагдсан бусад нууцыг агуулснаас бусад баримт бичиг, материал, мэдээлэлд нэвтрэх;
- 5.4. эрэн сурвалжлах сэтгүүл зүй эрхлэх;
- 5.5. олон нийтийн мэдээллийн хэрэгслээр бэлтгэсэн мэдээ мэдээлэл, материалаа өөрийн гарын үсэг, нууц нэрээр түгээх, түүгээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх;
- 5.6. төрийн байгууллагуудын нээлттэй хурал зөвлөгөөн болон бусад олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцох;
- 5.7. сэтгүүлчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан албан тушаалтантай ярилцах;
to be accepted by an official in connection with the implementation of journalistic activities;
- 5.8. тогтоосон журмын дагуу тэмдэглэл хөтлөх, шаардлагатай техник хэрэгсэл ашиглах;
- 5.9. нээлттэй шүүх хуралдаан, дайн бүхий байлдааны бүс, байгалийн гамшиг, олон нийтийг хамарсан байгалийн гамшиг бүхий газарт нэвтрэх;
- 5.10. хэвлэхэд бэлтгэсэн мэдээллийг шалгахын тулд тусгай мэргэжилтнүүдэд хандах;
- 5.11. олон нийтийн мэдээллийн хэрэгслээс даалгасан ажил нь хууль зөрчсөн бол хийхээс татгалзах;
- 5.12. бэлтгэсэн мэдээ мэдээлэл, материалыг засварлахдаа агуулгыг нь гажуудуулсан гэж үзвэл түүнд гарын үсэг зурахгүй байх, түүнийг олон нийтэд хэвлэн нийтэлж нэвтрүүлэхгүй байхыг шаардах;
- 5.13. мэдээллийн эх сурвалж болон зохиогчийн нэрийг нууцлахыг шаардах;
- 5.14. сэтгүүлчийн бэлтгэсэн материалыг хэвлэн нийтлэхдээ агуулгыг нь гажуудуулж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэлсэнтэй холбоотойгоор түүнд учирсан сэтгэл санааны /ёс суртахууны /болон эд хөрөнгийн хохирлыг /шүүхийн журмаар/нөхөн төлүүлэх/шаардах/ээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 5.15. төрийн бус байгууллага болон улсын сэтгүүлчдийн байгууллагад эвлэлдэн нэгдэх.
- 5.16. Сэтгүүлч холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх эдэлнэ.

6 дугаар зүйл. Сэтгүүлчийн үүрэг

- 6.1. Сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах үүрэг хүлээнэ.
 - 6.1.1. хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээг дагаж мөрдөх;
 - 6.1.2. бэлтгэсэн материалын үнэн зөвийг шалгаж, бодитой мэдээлэл өгөх;
 - 6.1.3. гэм буруугүй байх таамаглалын зарчмыг баримтлах;
 - 6.1.4. сэтгүүлчийн нууцыг задруулахгүй байх;
 - 6.1.5. сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлах;
 - 6.1.6. хувь хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийг хүндэтгэх.

6.2. Сэтгүүлч нь мэргэжлийн мэдээллийг хувийн /ашиг сонирхолд/ зорилгоор ашиглах, хувь хүний хувийн амьдралын тухай баримтыг нийтлэхгүй бөгөөд мэдээллийн эх сурвалж болон зохиогчийн зөвшөөрөлгүйгээр аудио, видео бичлэг хийх хэрэгслийг ашиглахгүй.

6.3. Сэтгүүлч нь хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээнэ.

7 дугаар зүйл. Сэтгүүлчийн нууц

7.1. Сэтгүүлчийн нууц гэдэг нь захидал харилцааны мэдээлэл, мөн түүнчлэн нэрээ нууцлах нөхцөлөөр иргэд болон бусад мэдээллийн эх сурвалжаас сайн дураар мэдээлсэн үйл баримт, үйл явдлыг хэлнэ.

7.2. Сэтгүүлч нь нууц мэдээллийг мэдээллийн эх сурвалжийн зөвшөөрөлгүйгээр задруулах, түүнчлэн өөрийн хувийн/шунахай/ ашиг сонирхол болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахыг хориглоно.

8 дугаар зүйл. Захидал харилцааны нууцлал

8.1. Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтанд Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9 дүгээр зүйл. Сэтгүүлчийн халдашгүй байдал

9.1. Сэтгүүлч мэргэжлийн үүргээ гүйцэтгэхдээ хувийн халдашгүй байдлын баталгааг эдэлнэ. Сэтгүүлч халдашгүй эрхтэй бөгөөд түүнийг энэ хууль болон бусад хуулиар хамгаална. Шүүмжтэй материал нийтэлсний төлөө сэтгүүлчийг дарамтлах, мөрдөн шалгахгүй.

9.1.1. Сэтгүүлчийн халдашгүй байдалд дараах зүйл хамаарна:

9.1.2. амь бие;

9.1.3. ажлын байр, хувийн болон албаны орон сууц;

9.1.4. эзэмшиж, ашиглаж байгаа хувийн болон албаны тээвэр, холбооны хэрэгсэл;

9.1.5. өөрийнх нь мэдэлд байгаа бичиг баримт, ачаа тээш, бусад эд хөрөнгө;

9.1.6. захидал харилцааны нууц.

9.3. Сэтгүүлч гэмт хэрэгт гэм буруутай нь иргэний шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор нотлогдоогүй бол ажил эрхэлж байх үедээ илэрхийлсэн үзэл бодлынх нь төлөө түүнийг ямар нэгэн хариуцлагад татахыг хориглоно.

9.4. Сэтгүүлч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, аюулгүй байдалд аюул занал учрах нөхцөл үүссэн болон энэ тухай мэдээлэл авсан бол цагдаагийн байгууллага энэ байдлыг таслан зогсоход чиглэсэн арга хэмжээг нэн даруй авах үүрэгтэй.

9.5. Энэ хуулийн 9.4-т заасан арга хэмжээг авах нөхцөл, журмыг Сэтгүүлчийн нэгдсэн эвлэл, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

9.6. Сэтгүүлч нь аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор бие хамгаалах хэрэгслийг эзэмших, биедээ авч явах эрхтэй.



10 дугаар зүйл. Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм

10.1.Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм нь сэтгүүлчийн хувийн байдал болон мэргэжлийн үүргээ гүйцэтгэхдээ баримтлах зан байдал тавигдах шаардлагыг тодорхойлсон хэм хэмжээ юм.

10.2.Ёс зүйн дүрмийг зөрчсөн сэтгүүлчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

10.3.Сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг Хэвлэл Мэдээллийн Зөвлөл батлан гаргана.

11 дүгээр зүйл. Сэтгүүлчийн эрэн сурвалжлах ажиллагаа

11.1.Сэтгүүлч мэдээлэл цуглуулах, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах эрхтэй.

11.2.Сэтгүүлч нь өөрийн мэргэжлийн мөрдлөгийн үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх, сайн дураараа төрийн байгууллага, иргэдийн өөрөө удирдах ёсны байгууллага, олон нийтийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага, байгууллага, албан тушаалтанд өгөх эрхтэй. Сэтгүүл зүйн мөрдлөгийн явцад олж авсан материал, баримт бичгийг хурааж авах, үзлэг хийхгүй. Сэтгүүлчид дараах зүйлийг хориглоно:

11.1.1.энэ хуульд заасан эрхээ урвуулан ашиглах;

11.1.2.шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараагүй байхад өөрийн байр суурийг олон нийтэд мэдээлэх, илэрхийлэх;

11.1.3.албан үүрэгтэй нь холбогдож, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах;

11.1.4. олон нийтэд мэдээлэхийг хязгаарласан, эсхүл албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, задруулах, Сэтгүүлчийн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зорилгоор ашиглах;

11.1.6. Сэтгүүлчийн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан бусад Сэтгүүлчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, заавар, удирдамж, чиглэл өгөх, авах, урьдчилан санал хэлэх;

11.1.7. Сэтгүүлчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээдээс шууд ба шууд бусаар тусламж авах, үйлчлүүлэх, ямар нэгэн давуу байдал, хөнгөлөлт, мөнгөн болон бусад урамшуулал, шагнал авах;

11.1.16. Сэтгүүлч улс төрийн аливаа байгууллагын удирдах болон бусад албан тушаал эрхлэх, улс төрийн байгууллага, сонгуульд нэр дэвшигчийн талаар олон нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийнх нь сурталчилгаанд оролцох, улс төрийн сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт олж өгөх, хандив өгөх;

11.1.19. Сэтгүүлч бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах;

11.2. Сэтгүүлч хувийн буюу иргэний эрхэд дараах хязгаарлалт тогтооно:

11.2.1.улс төрийн намд харьяалагдах;

11.2.2.улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллага болон иргэдэд улс төр, шашны асуудлаар байр сууриа илэрхийлэх;

12 дугаар зүйл. Сэтгүүлчийн ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт

12.1. Сэтгүүлч ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол оролцохоос татгалзах үүрэгтэй.

13 дугаар зүйл. Сэтгүүлчид хүлээлгэх хариуцлага

13.1. Сэтгүүлч зөвхөн хуульд захирагдах, шударга ёсны зарчим болон Сэтгүүлчийн ёс зүйг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн бол холбогдох сахилгын болон хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

13.2. Сэтгүүлчийн алдаа, гаргасан зөрчлөөс хувь хүн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорыг Иргэний хуульд заасан үндэслэлийн дагуу хариуцан арилгана.

14 дүгээр зүйл. Ёс зүйн хороодын бүтэц, бүрэлдэхүүн

14.1. Хэвлэл Мэдээллийн Зөвлөл нь сэтгүүлчийн ёс зүйн дүрэм, ёс зүйн хорооны үйл ажиллагаанд мөрдөх журмыг батална.

14.2. Хэвлэл Мэдээллийн Зөвлөл нь сэтгүүлчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт, ёс зүйн хорооны үйл ажиллагааны талаар жилд нэг удаа мэдээлэл хийнэ.

14.3. Хороон дарга ёс зүйн хорооны шийдвэрийн талаар олон нийтэд мэдээлэл өгнө.

15 дугаар зүйл. Сахилгын хэрэг үүсгэх эрх

15.1. Сэтгүүлчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд сахилгын хэрэг үүсгэхээр Ёс зүйн хороонд гомдол гаргана.

15.2. Энэ хуулийн 15.1-д заасан гомдлыг Ёс зүйн хороо заавал хянан үзнэ.

15.3. Ёс зүйн хорооны гишүүн гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шалгана.

15.4. Энэ хуулийн 15.3-д заасан шалгалтын дүнг Ёс зүйн хорооны гишүүн хянаж, сахилгын хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай тогтоол гаргана.

16 дугаар зүйл. Сахилгын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн

16.1. Ёс зүйн хороо сахилгын хэргийг 30 хоногийн дотор нийт гишүүний олонхын ирцтэй хэлэлцэн, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

16.2. Энэ хуулийн 15.1-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор иргэний хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

17 дугаар зүйл. Ёс зүйн хорооны шийдвэр

17.1. Ёс зүйн хороо сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

17.1.1. сахилгын шийтгэл ногдуулж, залруулга хийхийг үүрэг болгох,

17.1.2. сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох;

18 дугаар зүйл. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааны баталгаа

18.1. Сэтгүүлчийн эрх, нэр төр, алдар хүндийг хуулиар хамгаална.

18.2. Төр сэтгүүлчийг мэдээллийг чөлөөтэй олж авах, түгээх баталгааг бүрдүүлж, мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэх хамгаалалтыг баталгаажуулна.

18.3. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, мэргэжлийн үүргээ гүйцэтгэхдээ олж авсан аливаа мэдээллийг түүнээс шаардан авахыг хориглоно.

19 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн чанадад байгаа сэтгүүлч, Монгол дахь гадаадын сэтгүүлчийн үйл ажиллагаа .

19.1. Монгол Улсын сэтгүүлч өөрийн мэргэжлийн үйл ажиллагаагаа гадаадад . Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомжийн дагуу явуулна.

19.2. Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын сэтгүүлч Монгол Улсын сэтгүүлчтэй адил мэдээлэл цуглуулах, түгээхэд тэгш эрхтэй.

20 дугаар зүйл. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

20.1. Төрийн байгууллага, иргэдийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, улс төрийн нам, аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтнууд дараах үйлдлүүдэд хариуцлагыг хүлээнэ.

20.1.1. Цензурдсэн хяналт тавьсан ;

20.1.2. магадлан итгэмжлэлээс үндэслэлгүйгээр татгалзах, магадлан итгэмжлэлийг үндэслэлгүйгээр цуцлах замаар сэтгүүлчийн мэргэжлийн хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах;

20.1.3. сэтгүүлчийн шаардлагатай мэдээллийг шаардах, хүлээн авах эрхийг зөрчсөн;

20.1.4. сэтгүүлчийг дарамталж, мэргэжлийн үйл ажиллагаанд нь саад учруулах;

20.1.5. сэтгүүлчийн материал, шаардлагатай техникийн хэрэгслийг хууль бусаар хураан авах;

20.1.6. мэдээллийн эх сурвалж эсвэл зохиогчийн нэрийг тэдний зөвшөөрөлгүйгээр ил болгох.

20.1.7. Энэ хуулиар тогтоосон сэтгүүлчийн эрхийг зөрчих, нэр төр, алдар хүндэд нь халдах, заналхийлэх, хүчирхийлэл үйлдэх, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулан амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд нь халдах нь хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

21 дүгээр зүйл. Сэтгүүлчийн хариуцлага

21.1.Сэтгүүлч өөрийн бэлтгэсэн, тараасан мессеж, материалын үнэн зөвийг хуулиар тогтоосон журмаар хариуцна.

21.2.Сэтгүүлч дараах бодит байдалд нийцэхгүй материалыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах үүрэг хүлээхгүй.

21.2.1.хууль зөрчсөн;

21.2.2.зохиогчийн эрхийг зөрчсөн,

21.3.3.хүний эрхийн зөрчилтэй.

ГАРЫН ҮСЭГ





4.3 СЭТГҮҮЛЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг эдэлнэ гэж заасан. Үндсэн хуульд заасан энэхүү эрх, эрх чөлөөг бодитой хангах үүднээс 1998 онд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийг баталж хэвлэл мэдээллийн хэрэгслээр үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг баталгаажуулсан юм.

Мөн түүнчлэн Улсын Их Хурлаас 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг батлан гаргасан. Тус хуулийн зорилт нь төрийн үйл ажиллагааны ажиллагааны ил тод, нээлттэй, шударга, шуурхай, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг байдлыг хангах, иргэдийн мэдээлэл мэдээлэл авах эрх, эрх чөлөөг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Дээрх хуулиуд нь Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон.

Хоёр. Хуулийн төсөл боловсруулах болсон шаардлага

Монгол Улсын Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.4.5-д “Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ”, Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2008-2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 107-д “Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг баталгаажуулан хамгаалах” эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр “Хэвлэлийн эрх чөлөөний тухай” хуулийг боловсруулах” гэж тус тус заасан нь хуулийн төсөл боловсруулах хууль зүйн шаардлага болж байна.

